



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Хүнс, Хөдөө аж ахуйн газрын төсвийн зарцуулалт, хууль тогтоомжийн хэрэгжилт”-д хийсэн аудитын тайлан

АУДИТЫН КОД: : СБА-2020/06/-НА

Баруун-Урт 2020 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа
Утас: 70518396, Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер Г.Даваа
Утас: 70512123, Цахим хаяг: Davaag@audit.gov.mn

Ахлах аудитор С.Ариунбаяр
Утас: 70512123, Цахим хаяг: Ariunbayars@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунзул
Утас: 70512123, Цахим хаяг: Ariunzulb@audit.gov.mn

Агуулга

Агуулга	2
Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товчье	4
Дүрслэлийн товчье	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдээгдэл	5
БҮЛЭГ 1. Уст цэгийн тоог үе шаттайгаар нэмэгдүүлж байгаа боловч бэлчээрийн усан хангамж дутагдалтай, малын үүлдэр угсааг сайжруулах, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэхээр авч хэрэгжүүлсэн ажлууд үр дүнгүй байна.	6
Улс, орон нутгийн төсөв болон иргэн, аж ахуйн нэгжийн хөрөнгөөр уст цэгийн тоог үе шаттайгаар нэмэгдүүлж байгаа боловч бэлчээрийн усан хангамж дутагдалтай хэвээр байна.	6
1.1.1 Аймгийн хэмжээнд бэлчээрийн нийт талбайн 40.1 хувийг усжуулжээ.	6
1.1.2 Аймгийн хэмжээнд нийт бэлчээрийн 54.0 хувь нь даац хэтэрсэн байна.	7
1.1.3 ТЭДС-аас трактор зээлээр авсан иргэд одоог хүртэл төлбөрийг бүрэн төлж барагдуулаагүй байна.	8
1.2 Малын үүлдэр угсааг сайжруулах, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх ажил үр дүн муутай байна.	10
1.2.1 Үзэмчин хонь нийт хонин сүргийн 32.7 хувийг эзэлж байгаа ч цэврээр өсгөх бодлого хангалтгүй хэрэгжиж байна.	10
1.2.2 Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаасан эрчимжсэн мал ахуйг хөгжүүлэх, сүү, сүүн бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэхээр төлөвлөсөн зорилт хангалтгүй хэрэгжиж байна.	11
1.2.3 Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын хэрэгжилт орон нутагт хангалтгүй байна.	12
1.2.4 Малын үзлэг ангилалтыг хийсэн ажлын дүгнэлт, зөвлөмж, цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээр малчдад заавар чиглэл өгөгдөөгүй байна.	12
1.2.5 МҮА-аас малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлсон судалгаанд дүн шинжилгээ хийгээгүй байна.	13
1.3 Үлийн цагаан оготной тэмцэх ажлын санхүүжилт 58.4 сая төгрөгийг зориулалт бус зарцуулж, гүйцэтгэлийг 82.7 хувийн хэрэгжилттэйгээр тайлагнажээ.	15
1.3.1 Аймгийн хэмжээнд 152.0 мянган га талбайд үлийн цагаан оготнойн устгал хийж хэрэгжилтийг 82.7 хувьтай үнэлжээ.	15
1.3.2 Зарим сумд үлийн цагаан оготно устгахад гүйцэтгээгүй ажлыг гүйцэтгэснээр мэдээлж, 58.4 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулснаар тайлагнажээ.	15
БҮЛЭГ 2. Аймгийн хэмжээнд газар тариалан хөгжүүлэх нэгдсэн бодлого хэрэгжүүлээгүй, ХАА-н салбар мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай, худалдаа, үйлдвэр үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхээр ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байгаа боловч үр дүнг тооцох талаар хангалтгүй ажиллаж байна.	16
2.1 ЖДҮХС-ийн зээлийг хууль журмын дагуу олгож, төслийг зориулалтын дагуу хэрэгжүүлж байна.	16
2.1.1. ЖДҮХС-ийн зээлд хамрагдахаар ирүүлсэн төслийн 48.0 хувь хууль, журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангаагүйгээс буцаагджээ.	16
2.1.2. Зээлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж төслийг зориулалтын дагуу хэрэгжүүлж байна.	17
2.2 Аймгийн хэмжээнд газар тариаланг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлээгүй, ХХААЯ-аас хийсэн үнэлгээгээр газар тариалангийн үзүүлэлтээр улсын хэмжээнд хамгийн доогуур үнэлэгджээ.	17
2.2.1 Аймгийн хэмжээнд газар тариалангийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх хэрэгцээ шаардлага үүссэн байна.	17
2.2.2 Аймгийн хэмжээнд 2,250 га-д улаан буудай тариалснаас 1,550 га буюу 68 хувьд ургац авч чадаагүй байна.	19
2.2.3 Аймгийн хэмжээнд аж ахуйн нэгжүүд 5 төрлийн сортоор улаан буудай тариалж байна.	20
2.3 Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор үзэсгэлэн худалдаа, уралдаан тэмцээн зохион байгуулдаг боловч энэ нь үр дүнтэй арга хэмжээ төлөвлөсөн гэж харагдахгүй байна.	20
2.3.1 Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийн 34.9 хувийг хувиараа худалдаа, үйлчилгээ үзүүлж байгаа иргэд эзэлж байна.	20
2.3.2 Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хүрэлцээ, хангамжийн судалгааг журамд заасны дагуу гаргаж нэгтгэжээ.	21
2.3.3 ЗГ-аас баталсан үндэсний хөтөлбөрийн хүрээнд оёдлын үйлдвэртэй болсон боловч одоогоор ажиллахгүй байна.	22
2.3.4 Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний байгууллагуудын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх талаар зорилт дэвшүүлээгүй байна.	23
БҮЛЭГ 3. Үндсэн хөрөнгийн тооллогыг чанаргүй гүйцэтгэснээс хөрөнгө дутагдсан, хөрөнгийн хадгалалт хамгаалалтад эрсдэл учирсан, салбарын хэмжээнд хийгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр улсын дунджаас доогуур үнэлэгджээ.	24
3.1 Батлагдсан төсвийн 3.4 хувийг зориулалт бус зарцуулсан, хөрөнгийн тооллогоор 149.0 сая төгрөгийн хөрөнгө дутагдаж байна.	24
3.1.1 Батлагдсан төсвөөс 11.2 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан нь хяналт шалгалтаар илэрсэн байна.	24
3.1.2 Орон нутгийн төсөв, Хөдөө аж ахуйн яамнаас олгосон нэмэлт санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулжээ.	25
3.1.3 Дансанд бүртгэлтэй 149.0 сая төгрөгийн 25 хөрөнгө тухай байгууллагад биетээр байхгүй байна.	25

3.1.4 Мал сүргийн үзлэг ангилалт, генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулалт хийлгүй шууд гэрээ байгуулж, гүйцэтгүүлжээ.....	26
3.2 ХАА-н тасагт ажиллаж байгаа нийт ажилчдын 42.9 хувь нь мэргэжлийн бус бөгөөд мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байгаа нь үйл ажиллагаа доголдоход нөлөөлжээ.	27
3.2.1 Сумдын ХАА-н тасагтай байгуулсан гэрээний хэрэгжилт хангалтгүй байна.	27
3.2.2 Сумын хөдөө аж ахуйн тасагт мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байна.	27
3.2.3 Байгууллагын сургалтын төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй байна.	28
3.2.4 ХХААЯ-аас хийгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр улсын дунджаас доогуур үнэлэгджээ.	29
Холбогдох байгууллагын санал:	30
Саналд өгсөн тайлбар:.....	31
Тайлангийн төслийг бүхэлд нь ерөнхийд нь зөвшөөрсөн бөгөөд ирүүлсэн тайлбарыг авч үзвэл:.....	31
ДҮГНЭЛТ:	31
ЗӨВЛӨМЖ:.....	32

Товчилсон үгийн тайлбар

АЗДТГ	Аймгийн засаг даргын тамгын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЖДҮДС	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан
МАА	Мал аж ахуй
МЭҮТ	Мал эмнэлгийн үржлийн тасаг
МЭУА	Мал эмнэлгийн үржлийн алба
МЭГ	Мал эмнэлгийн газар
МХГ	Мэргэжлийн хяналын газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ӨМӨЗО	Өвөр монголын өөртөө засах орон
СХС	Сум хөгжүүлэх сан
ТАСЗ	Төрийн албаны салбар зөвлөл
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
УИХ	Улсын Их Хурал
ХХҮГ	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХАА	Хөдөө аж ахуй
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани
ХШҮХ	Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс
УЦУОШГ	Ус цаг уур орчны шинжилгээний газар
ШШГА	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Алба
ШӨХТГ	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөөх газар

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Бэлчээр усжуулалтын судалгаа	7
2	Бэлчээрийн даацын судалгаа	8
3	Бог малын судалгаа	10
4	Мал сүрэгт ангилалт хийсэн судалгаа	13
5	Малын генетик нөөцийн төлөв байдлын судалгаа	14
6	Хүнсний хангамжийн судалгаа	21
7	Үйлдвэржилтийн төлөвлөлтийн судалгаа	22
8	Дутагдсан хөрөнгийн жагсаалт	25
9	Хяналт-шинжилгээ, үнэлгээний харьцуулсан судалгаа	29

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа худгийн судалгаа	6
2	Төмс, хүнсний ногоо тариалалт, ургац хураалтын судалгаа	18
3	Үр тариа болон малын тэжээл тариалалт, ургац хураалтын судалгаа	19

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалтыг үндэслэн Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2019 оны 05 дугаар тогтоол, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэв.
Аудитын зорилт	“Хүнс, хөдөө аж ахуйн газрын төсвийн зарцуулалт, хууль тогтоомжийн хэрэгжилт”-д нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, Сүхбаатар аймгийн Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.
Аудитын хамарсан хүрээ	Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны үйл ажиллагаа, төсөв санхүүгийн тайлан, мэдээ, дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө, тайлан, тасаг нэгжийн ажлын тайлан, гэрээ, гүйцэтгэл болон холбогдох бусад баримт материалд тулгуурлан гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 400, 4000-4100 үндэслэн боловсруулсан Нийцлийн аудитын түр журамд заасан арга зүйг ашиглан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон зээл олголт, санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материал, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитын төлөвлөгөөг 2020 оны 05 дугаар сарын 05-ний өдрийн дотор батлуулж, талбарын ажлыг 2020 оны 05 дугаар сарын 06-ний өдрөөс 2020 оны 06 дугаар сарын 05-ний өдөр хүртэл гүйцэтгэж, тайланг 2020 оны 06 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн 2020 оны 06 дугаар сарын 12-ны дотор боловсруулж, үе шатны хяналтыг хийлгэн, Тэргүүлэх аудиторт 2020 оны 06 дугаар сарын 15-ний дотор танилцуулж, баталгаажуулан аймгийн Засаг дарга болон ХХААГ-т 2020 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор хүргүүлнэ
Хүндрэл бэрхшээл	Тус аудитыг гүйцэтгэх явцад Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн хуульд заасны дагуу цагалбарт хугацаатай аудитууд болон ҮАГ-аас нэгдсэн удирдамжтай аудитууд хийгдсэнээс шалтгаалан тул уг аудитыг төлөвлөгөөнд заасан хугацаанд хийж гүйцэтгэж чадаагүй болно.

БҮЛЭГ 1. Уст цэгийн тоог үе шаттайгаар нэмэгдүүлж байгаа боловч бэлчээрийн усан хангамж дутагдалтай, малын үүлдэр угсааг сайжруулах, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэхээр авч хэрэгжүүлсэн ажлууд үр дүнгүй байна.

Улс, орон нутгийн төсөв болон иргэн, аж ахуйн нэгжийн хөрөнгөөр уст цэгийн тоог үе шаттайгаар нэмэгдүүлж байгаа боловч бэлчээрийн усан хангамж дутагдалтай хэвээр байна.

1.1.1 Аймгийн хэмжээнд бэлчээрийн нийт талбайн 40.1 хувийг усжуулжээ.

1.1.1.1 Аймгийн хэмжээнд 2018 оны байдлаар 3,066 худаг бүртгэлтэй бөгөөд дунджаар бэлчээрийн 2,258.7 га талбай тутамд 1 худаг ногдож байна.

Худаг, уст цэгийн тооллого судалгааг 3 жил тутамд хийсэн бөгөөд өмнөх онуудын тооллого судалгаанаас худгийн тоо тогтмол нэмэгдсэн байна. Худгийн тоог хүснэгтээр харьцуулан харуулбал: График 1



(Эх сурвалж 1212.mn сайтаас)

Графикаас харахад инженерийн хийцтэй худаг өмнөх оноос 254 буюу 12.9 хувиар нэмэгдсэн бөгөөд аймаг сумд бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор 2017-2018 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 237.3 сая төгрөгийг гүн өрмийн худаг гаргахад зарцуулсан нь нөлөөлсөн байна. Мөн аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр аймгийн нутаг дэвсгэрт уст цэг тогтоох ажлыг 90.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлснээр тогтоосон цэгт өрөм тавьж хулаг гаргах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

1.1.1.2 Худаг, уст цэгийн тоо жил бүр нэмэгдэж байгаа хэдий ч бэлчээрийн усан хангамжийг бүрэн гүйцэт хангаж чадахгүй байна. Тухайлбал: Аймгийн хэмжээнд бэлчээрийн талбайн 40.1 хувийг усжуулж байна. Газар нутгийн хэмжээ их Асгат, Баяндэлгэр, Онгон, Сүхбаатар, Эрдэнэцагаан зэрэг сумдад бэлчээрийн усжуулалт аймгийн дунджаас доогуур буюу нийт нутгийн 23.8-37.0 хувийг усжуулж байна. Харин нэг худагт ногдох бэлчээрийн талбайн хэмжээгээр авч үзвэл: Асгат, Сүхбаатар, Онгон суманд 3,082.72-4,380.47 га талбайд нэг худаг ногдож байгаа нь бэлчээрийн усан хангамж хамгийн ихээр дутагдаж байгааг илтгэж байна.

Бэлчээр усжуулалтын судалгааг хүснэгтээр харуулав. Хүснэгт 1

Сумын нэр	Худгийн тоо			Бэлчээрт ашиглагдаж байгаа газар /га/	Нэг уст цэгт ногдох бэлчээрийн газрын хэмжээ /га/	Бэлчээр усжуулалтын хувь
	2012 он	2015 он	2018 он			
Баруун-Урт	193	210	349	-	-	-
Асгат	160	174	178	713,227.11	4,006.89	29.6
Баяндэлгэр	246	235	390	726,381.88	1,862.52	32.7
Дарьганга	22	115	94	14,624.17	155.58	28.4
Мөнххаан	190	301	309	716,642.98	2,319.23	50.9
Наран	87	109	108	189,230.49	1,752.13	74.2
Онгон	122	158	176	542,558.37	3,082.72	30.7
Сүхбаатар	304	277	284	1,244,052.16	4,380.47	23.8
Түвшинширээ	111	212	187	431,819.37	2,309.19	58.3
Түмэнцогт	167	152	161	187,672.11	1,165.67	96.5
Уулбаян	129	183	194	490,149.66	2,526.54	96.5
Халзан	179	165	168	373,694.05	2,224.37	51.3
Эрдэнэцагаан	386	435	468	1,295,268.48	2,767.67	37.0
Нийт	2,296	2,726	3,066	6,925,320.83	2,258.75	40.1

1.1.1.3 Судалгаанаас Баруун-Урт суманд 349 худаг бүртгэгдсэн бөгөөд үүнээс тухайн сумын иргэний эзэмшилд байгаа боловч өөр сумын нутаг дэвсгэрт гаргасан бэлчээрийн зориулалтаар ашиглагдаж байгаа худгийг тус суманд бүртгэгдсэн байна.

1.1.1.4 Орон нутгаас Ус үндэсний хөтөлбөрийн хүрээнд усны нөөцийн хуримтлалыг бий болгох, усны хангамжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд "Сүхбаатар ойжуулалт сум дундын ой анги" ОНӨААТҮГ-т гүн өрмийн худгийн авто машин эзэмшүүлж, жилд 5 худаг гаргаж, хүлээлгэн өгөхөөр гэрээлсэн боловч гэрээний гүйцэтгэл он дамжин хэрэгжжээ. Цаашид гэрээнд заасан хугацаанд гэрээний гүйцэтгэлийг хангуулах, авто машины түрээсийн гэрээний үүргийн биелэлтийг сайжруулах шаардлагатай байна.

1.1.2 Аймгийн хэмжээнд нийт бэлчээрийн 54.0 хувь нь даац хэтэрсэн байна.

1.1.2.1 Бэлчээрийн даацын судалгааг УЦУОШГ-аас Монгол улсын Засгийн газрын 2015 оны 286¹ дугаар тогтоолын дагуу бэлчээрийн ургац, малын тоо, талбайн хэмжээ, бэлчээр ашиглах хугацаа зэрэг мэдээлэл дээр үндэслэн гаргадаг. Харин ХХААГ мэргэжлийн байгууллагаас гаргасан судалгаа дүгнэлтийг ашигладаггүй, бэлчээрийн төлөв байдлыг үнэлэх, цаашид хэрэгжүүлэх ажлыг төлөвлөх, бэлчээрийг хуваарьтай ашиглах ажил үр дүнгүй байна.

¹ Журам батлах тухай

УЦУОШГ-аас гаргасан бэлчээрийн даацын судалгааг сум тус бүрээр авч үзвэл.
Хүснэгт 2

Сумын нэр	Бэлчээрт ашиглагдаж байгаа талбай /га/	Бэлчээрийн даац /га/			
		нөөцтэй	хүрэлцээтэй	хэтэрсэн	
Асгат	713,227.11	534,920.33		178,306.78	
Баяндэлгэр	726,381.88		239,706.02	486,675.86	
Дарьганга	14,624.17		3,656.04	10,968.13	
Мөнххаан	716,642.98	143,328.60		573,314.38	
Наран	189,230.49		126,784.43	62,446.06	
Онгон	542,558.37		406,918.78	135,639.59	
Сүхбаатар	1,244,052.16	746,431.30		497,620.86	
Түвшинширээ	431,819.37	172,727.75	172,727.75	86,363.87	
Түмэнцогт	187,672.11		61,931.80	125,740.31	
Уулбаян	490,149.66	98,029.93	196,059.86	196,059.86	
Халзан	373,694.05	186,847.03	93,423.51	93,423.51	
Эрдэнэцагаан	1,295,268.48			1,295,268.48	
	Нийт	6,925,320.83	1,882,284.93	1,301,208.19	3,741,827.71
		Эзлэх хувь	27.2	18.8	54.0

Судалгаанаас 2019 оны байдлаар нийт бэлчээрийн газрын 54.0 хувь буюу 3,741.8 мянган га талбайн даац хэтэрч өмнөх онтой харьцуулж үзэхэд 9.6 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь тухайн жилд хур тунадас оройтож орсноос ургамлын гарц муу, жилээс жилд малын тоо толгой нэмэгдсэн, мөн өөр аймаг, сумын малчид отор, нүүдлээр ирж нутагласан зэрэг хүчин зүйлс бэлчээрийн даац хэтрэхэд нөлөөлж байна.

1.1.2.2 Бэлчээрийн даацын судалгаанд үндэслэн холбогдох албан тушаалтнууд дүн шинжилгээ хийж өвөлжилт, хаваржилтыг эрсдэл багатай даван туулах, өвс, тэжээлийн нөөцийг бүрдүүлэх төлөвлөгөө гаргаж шаардагдах хөрөнгийг орон нутгийн түвшинд шийдвэрлүүлж байх нь зүйтэй байна.

1.1.3 ТЭДС-аас трактор зээлээр авсан иргэд одоог хүртэл төлбөрийг бүрэн төлж барагдуулаагүй байна.

1.1.3.1 Аймгийн хэмжээнд өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд өвс 1,600 тонн, тэжээл 430 тонныг бэлтгэхээр төлөвлөснөөс аймгийн аюулгүйн нөөцөд 300 тонн өвс, 40.0 тонн тэжээл бэлтгэхээр төлөвлөсөн. Аюулгүйн нөөц бэлтгэсэн байдлыг авч үзвэл: Сумдад 1050 тонн буюу 52.5 мянган боодол өвс, 155 тонн тэжээл бэлтгэсэн бол аймгийн нөөцөд 480 тонн буюу 24.0 мянган боодол өвс 20 тон тэжээл бэлтгэсэн байна. Малын хүчит тэжээл бэлтгэх ажил 40.7 хувьтай буюу төлөвлөсөн хэмжээнээс 255 тонноор дутуу бэлтгэхэд Баяндэлгэр, Наран, Онгон, Баруун-Урт сумд хүчит тэжээл бэлтгэж нөөцлөөгүй нь нөлөөлсөн байна.

1.1.3.3 Аймгийн аюулгүй нөөцөд бэлтгэж байгаа өвс тэжээлийг нярвын тайлангаар бүртгэж, санхүүгийн тайланд толилуулаагүй, тооллого тооцоо боддоггүй, нярав бичмэл дэвтэр дээр орлого, зарлага болгож байгаа нь үр ашиггүй зарцуулах, хөрөнгө үрэгдэх, сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг бий болгож, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх заалтыг зөрчсөн байна.

1.1.3.4 Нөөцөд бэлтгэсэн өвс, тэжээлийг аймгийн засаг даргын шийдвэрээр захиран зарцуулж байгаа боловч өвсний хадгалалт, хамгаалалтад тавих хяналт хангалтгүй байна. Тухайлбал: *Тайлант онд 24.0 мянган боодол өвс авч өвөлжилт хүндэрсэн сумдад 15.0 мянган боодол, иргэдэд 460 боодол өвсийг үнэ төлбөргүйгээр олгосон байна. Харин хадгалалтын явцад задарсан өвсийг тухай бүр тэмдэглэл хөтлөөгүй хэдий хэмжээний өвс задарсан нь тодорхойгүйгээс өвсний үлдэгдэл зөрүүтэй байна.*

1.1.3.5 Нярав хүлээн авсан өвснөөс 6,238 боодол өвс задарснаар тайлагнасан бөгөөд зарцуулсан болон задарсан өвсний тооцоог авч үзвэл үлдэгдэл 0.5 мянган боодлоор зөрүүтэй байна. Иймд аюулгүйн нөөцөд бүртгэлтэй өвс тэжээлийг данс бүртгэлд тусгах, өвсний зарцуулалт, хадгалалтад тавих хяналтыг сайжруулах, материалын тооллого тооцоог тухай бүр хийж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

1.1.3.6 Тариалан эрхлэгчдийг дэмжих сангаас 2015-2016 онд 56 иргэн, хуулийн этгээдэд 6.0 сая төгрөгийн өртөгтэй бага оврын 59 тракторыг гэрээний үндсэн дээр зээлээр олгосон байна. Үүнээс 40 иргэн, хуулийн этгээдэд 42 тракторыг тус бүрийг нь 2400 боодол өвс авахаар гэрээ байгуулж олгосон бол 16 иргэнд 17 тракторыг лизингээр гэрээ байгуулж олгосон байна.

1.1.3.7 Гэрээний дагуу 14 иргэн 16 тракторын үнийг бүрэн төлсөн бол 14 иргэн төлбөр огт төлөөгүй байна. Одоогоор зээлд хамрагдсан 43 иргэн, хуулийн этгээд 181.5 сая төгрөгийн үлдэгдэл төлбөрийг барагдуулаагүй байна. Үүнээс гэрээний үүргээ биелүүлээгүй 13 иргэнийг шүүх хяналтын байгууллагад шилжүүлж эвлэрүүлэн зуучлахаар төлбөрийг барагдуулах гэрээ байгуулсан ч одоог хүртэл гэрээний үүргээ биелүүлээгүй байна. Иймд дээрх 13 иргэний төлбөрийг ШШГА-нд хандаж төлбөрийг албадан гүйцэтгүүлэх нь зүйтэй байна.

1.1.3.8 Гэрээний дагуу зээлээр авсан тракторын төлбөрийг бүрэн төлөөгүй 28 иргэн, хуулийн этгээдийн 126.8 сая төгрөгийн төлбөрт акт тогтоов.

1.1.3.9 Тракторын төлбөрийг өвсөөр төлөхөөр гэрээ байгуулсан иргэдээс 140.7 сая төгрөгийн үнэлгээ бүхий 56.2 мянган боодол өвсийг ХХАА-н газарт хүлээлгэн өгсөн байна. Үүнээс орон нутагт өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрсэнтэй холбоотойгоор аймгийн засаг даргын шийдвэрээр 109.0 сая төгрөгийн өвсийг малчдад үнэ төлбөргүйгээр тараасан байна. Гэвч малчдад тараасан өвсний төлбөрийг төлөөгүйгээс гэрээнд заасан хугацаанд төлбөрийг бүрэн барагдуулсан иргэд ТЭДС-д одоог хүртэл өртэй байгаа бөгөөд цаашид төсөл, хөтөлбөрт болон хөнгөлөлттэй зээлд хамрагдахад хүндрэл бэрхшээл үүсэж байна. Иймд аймгийн засаг даргын шийдвэрээр малчдад үнэ төлбөргүй олгосон өвсний тооцоог аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, СТСХ-ийн холбогдох мэргэжилтэнтэй тооцоо нийлж төлбөрийг барагдуулах албан шаардлага хүргүүлээ.

1.2 Малын үүлдэр угсааг сайжруулах, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх ажил үр дүн муутай байна.

1.2.1 Үзэмчин хонь нийт хонин сүргийн 32.7 хувийг эзэлж байгаа ч цэврээр өсгөх бодлого хангалтгүй хэрэгжиж байна.

1.2.1.1 Аймгийн хэмжээнд Баяндэлгэрийн улаан ямаа, Эрдэнэцагааны үзэмчин хонь, Дорнод талын махны хэвшлийн үхрийн үүлдэр ХХААХҮЯ-д албан ёсны бүртгэлтэй байна.

1.2.1.2 Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Малын үүлдэр, удам угсааг сайжруулах зорилтын хүрээнд Үзэмчин хонь, Баяндэлгэрийн улаан ямааг цэврээр өсгөх, улс, бүсийн хэмжээнд сурталчлан таниулж үржлийн малын борлуулалтыг нэмэгдүүлэхээр тусгасан. Уг зорилтын хүрээнд “Баяндэлгэрийн улаан” үүлдрийн ямааны үржил, селекцийн ажлын хөтөлбөр боловсруулсан боловч батлуулаагүй буюу хөтөлбөр хэрэгжээгүй байна.

1.2.1.3 Зарим сумд засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр бог малын үүлдэр угсааг сайжруулах зорилгоор Баяндэлгэр улаан үүлдрийн ямаа, Эрдэнэцагааны үзэмчин хуцны хээлтүүлэгчийг худалдан авч нийлүүлэгт оруулж байгаа боловч сумдын хөдөө аж ахуйн тасгаас тооцоо судалгаа, үр дүнг тооцох талаар хангалтгүй ажиллаж байна. Тухайлбал: Баяндэлгэр улааны ямаа, Эрдэнэцагааны үзэмчин хонины цөм сүргийг цэврээр нь өсгөх талаар нарийвчилсан тооцоо судалгаа хийгдээгүй байна. Баяндэлгэр улааны ямаа, Эрдэнэцагааны үзэмчин хонины судалгааг харуулав.

/мянган толгой/

малын төрөл	2017			2018			2019		
	НИЙТ МАЛЫН ТОО	ҮЗЭМЧИН ХОНЬ	Улаан ямаа	НИЙТ МАЛЫН ТОО	ҮЗЭМЧИН ХОНЬ	Улаан ямаа	НИЙТ МАЛЫН ТОО	ҮЗЭМЧИН ХОНЬ	Улаан ямаа
Хонь	1815.3	733.9		1922.1	752.7		1971.2	645.6	
Ямаа	1152.4		681.9	1207.5		744.2	1247.4		612.8

(Эх сурвалж: ХХААГ-ын МҮА, 1212.mn цахим сайт)

1.2.1.4 ХХААГ-аас 2019 онд Эрдэнэцагааны үзэмчин хонь нийт хонин сүргийн 32.7 хувь, Баяндэлгэрийн улаан ямаа нийт ямаан сүргийн 49.1 хувийг эзэлж байгаа судалгаа гарчээ. Энэ нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна. Дээрх судалгаанаас үүлдрийн бог малын тухайн сүрэгт эзлэх хувь өндөр харагдаж байгаа нь нэг талаас хээлтүүлэгчээс гарсан төл буюу сайржуулсан малын тоог цэврэр өссөнөөр тайлагнасан. Нөгөө талаар бог малын үүлдэрлэг чанарыг оновчтой тодоорхойлж чадаагүйтэй холбоотой байна. Уг бодлого, зорилтын хүрээнд үүлдрийн малыг цэврээр өсгөх бодлогыг Эрдэнэцагаан, Баяндэлгэрт байгаа үндсэн малын тоонд түшиглэн тодорхойлох шаардлагатай байна.

1.2.1.5 Бог малын үүлдэр угсааг сайжруулах зорилгоор ӨМӨЗО-ноос 60.0 сая төгрөгийн өртөгтэй үзэмчин үүлдрийн 12 хуц худалдан авч, үржүүлэгт оруулжээ. Тус үзэмчин үүлдрийн хуцыг данс бүртгэлд тусгалгүйгээр малчнаас малчны хооронд дамжуулан мал сүрэгт хээлтүүлэг хийлгэсэн, нөхөн үржүүлэх бодлогыг зөв авч хэрэгжүүлээгүйгээс ихэнх хуц үхэж, үрэгдсэн байна. Малын үүлдэр угсааг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн уг арга хэмжээ нь үр дүнгээ өгсөн эсэх нь тодорхойгүй, хэдэн малчны болон ямар цөм сүрэгт үүлдэр угсаа сайжирсан

зэрэг суурь тооцоо, судалгаагүй ажиллаж байна. Үхэж, үрэгдсэн үзэмчин үүлдрийн хуцын нөхцөл шалтгааныг тодорхойлж, хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг аудитаар зөвлөмж болголоо.

1.2.2 Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан эрчимжсэн мал ахуйг хөгжүүлэх, сүү, сүүн бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэхээр төлөвлөсөн зорилт хангалтгүй хэрэгжиж байна.

1.2.2.1 Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, сүү цагаан идээний хангамжийг нэмэгдүүлэх, тухайн чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийг хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжиж ажиллахаар тусгасан.

1.2.2.2 Засгийн газрын 2018 оны 400² дугаар тогтоолоор батлагдсан Үндэсний хөтөлбөр, аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор зарим аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжин, ЖДҮДС-ийн хөнгөлөлттэй зээлд хамруулж, 2018 онд 1 аж ахуйн нэгжид 100.0 сая, 2019 онд 3 иргэн, аж ахуйн нэгжид 520.0 сая төгрөгийг олгожээ.

1.2.2.3 Орон нутгийн хүн амын хэрэгцээнд сүү, сүүн бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэхээр Аймгийн Засаг даргаас сум бүрт 50 хүртэлх үнээний тасаг байгуулах захирамж гарсан боловч Эрдэнэцагаан, Дарьганга, Мөнххаан, Халзан сумаас бусад нь хэрэгжүүлээгүй байна.

1.2.2.4 Мөн ХХААХҮЯ-аас орон нутгийн сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлдвэрийн аргаар боловсруулсан бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх, сүүний үнээний эрчимжсэн фермийн үйл ажиллагаа явуулж байгаа малчдыг дэмжих зорилгоор 61,1 сая төгрөгийн өртөг бүхий 14 нэр төрлийн 258 ширхэг тоног төхөөрөмжийг Баруун-Урт, Дарьганга, Сүхбаатар сумын иргэн аж, ахуйн нэгжид олгожээ. Тус тоног төхөөрөмжийг төсөл сонгон шалгаруулж олгоогүйгээс хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнгүй болсон, мөн төслийн үр дүнг давтамжтай үнэлгээгүй, уг зорилт, хөтөлбөр арга хэмжээг төсөл хэрэгжүүлэгч иргэнд сайтар ойлгуулаагүй, хэрэгцээ шаардлагатай эзэндээ очиж чадаагүйгээс төслийн үр дүн гараагүй байна.

1.2.2.5 Сумд 2017-2019 онд СХС-аас эрчимжсэн мал аж ахуй, сүү, сүүн бүтээгдэхүүн, фермерийн чиглэлээр иргэн, хуулийн этгээдэд нийт 42 төсөлд 445.5 сая төгрөгийг олгосон боловч ихэнх иргэн, хуулийн этгээд төслийг хэрэгжүүлээгүй байна. Дээрх нөхцөл байдлаас дүгнэж үзэхэд аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан эрчимжсэн мал ахуйг хөгжүүлэх, сүү, сүүн бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнгүй, зорилт бүрэн хэрэгжээгүй байна.

1.2.2.6 Мөн ХХААГ-ийн эрчимжсэн мал аж ахуйн хариуцсан мэргэжилтний гаргасан судалгаагаар аймгийн хэмжээнд эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр 61 иргэн, хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байгаагаар тайлагнасан байна. Өөрөөр хэлбэл, судалгаагаар эрчимжсэн мал аж ахуйн нэр томьёонд хамаарахгүй, 1-3 сүүний чиглэлийн үнээтэй иргэнийг эрчимжсэн мал ахуй эрхлэгчээр бүртгэж байгаа нь улсын хэмжээнд өгч байгаа тоо мэдээ зөрүүтэй, алдаатай илэрхийлэгдэж байгааг илтгэж байна.

² Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр

1.2.2.7 Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх нарийвчилсан тооцоо судалгаа, төлөвлөгөө байдаггүй, иргэн хуулийн этгээдийг эрчимжсэн мал аж ахуй эрхлэх орчин нөхцөлөөр хангах үйл ажиллагаа оновчтой биш, бодлогын хэрэгжилт хангалтгүй байна.

1.2.2.8 Иймээс АЗДТГ-ын ХОХБТХ-тэй хамтран Засгийн газрын 2018 оны 400 дугаар тогтоолоор батлагдсан Үндэсний хөтөлбөрт тулгуурлан “Аймгийн эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх дэд хөтөлбөр” боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж, ажиллах шаардлагатай байна.

1.2.3 Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын хэрэгжилт орон нутагт хангалтгүй байна.

1.2.3.1 Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд малчдын мэдлэг, чадварыг сайжруулах талаар тусгайлан зорилт дэвшүүлээгүй байна. Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт малчдыг сургалтад хамруулах, туршлага судлуулах талаар дараах зорилтыг төлөвлөсөн байна.

- ХХАА-н салбарын мэргэжилтэн, малчид, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг гадаад, дотоодын туршлага судлах аялал, сургалтад үе шаттайгаар хамруулах ажлыг зохион байгуулж, шинжлэх ухааны ололт, сайн туршлага, инновац нутагшуулна.
- Байгаль хамгаалах сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж энэ чиглэлээр ажиллах малчдын бүлэг, нөхөрлөл байгуулах, ажиллаж буй бүлэг, нөхөрлөлд дэмжлэг үзүүлэх замаар байгаль орчны тогтвортой хөгжлийг хангана.
- Залуучуудад мал аж ахуйн чиглэлийн мэргэжил олгож, малгүй буюу мал цөөтэй малчин өрхийг малжуулах замаар тогтвортой хөдөлмөр эрхлэх боломжийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч ажиллана.

1.2.3.2 Дээрх зорилтын хүрээнд ӨМӨЗО-ны Зүүн үзэмчин хошуу, Шилийн гол аймагт 45 малчныг эрчимжсэн МАА, мах боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцуулсан. Мөн байгалийн нөөц баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нэн ховор болон ховор амьтдыг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр зарим малчны бүлгүүдэд сургалт зохион байгуулсан байна.

1.2.3.3 Харин малгүй буюу цөөн малтай 18-35 насны 29 иргэнд 2390 толгой малыг олгосон бол зарим өрхийг туслах малчнаар ажиллуулахад сумын ЗДТГ-тай хамтран ажиллажээ.

1.2.3.4 Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт арга хэмжээнээс өөрөөр малчид, малчин өрхөд чиглэсэн сургалт, үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлээгүй нь УИХ-ын 2009 оны 39 дүгээр тогтоолоор батлагдсан төрөөс малчдын талаар баримтлах бодлогын хэрэгжилт хангалтгүй байгааг илтгэж байна.

1.2.4 Малын үзлэг ангилалтыг хийсэн ажлын дүгнэлт, зөвлөмж, цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээр малчдад заавар чиглэл өгөгдөөгүй байна.

1.2.4.1 Аймгийн хэмжээнд мал сүрэгт хийх ангилалтыг ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А/102 дугаар тушаал, Аймгийн засаг даргын 2019 оны А/260 дугаар

захирамжийн дагуу Үзэмчин хонь ХХК, Баясгалант сүрэг ХХК, Түмэнцогт ОНӨҮГ-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн байна.

1.2.4.2 Дээрх аж ахуйн нэгжүүд 247 малчин өрхийн 29,920 толгой малд ангилалт хийснээс 13,216 толгой хээлтүүлэгч, 16,704 толгой хээлтэгч малыг хамруулсан бөгөөд гэрээнд заасан тооноос 78 толгой малыг илүү хамруулсан байна. Мал сүрэгт ангилалт хийсэн байдлыг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 4

д/д	Аж ахуйн нэгжийн нэр	ангилалтад хамрагдах мал /толгой/		ангилалтад хамруулсан мал /толгой/	
		хээлтэгч	хээлтүүлэгч	хээлтэгч	хээлтүүлэгч
1	Үзэмчин хонь ХХК	5,000	1,000	5,078	1,000
2	Үзэмчин хонь ХХК	710	132	710	132
3	Баясгалант сүрэг ХХК	6,000	800	6,000	800
4	Баясгалант сүрэг ХХК		10,700		10,700
5	Түмэнцогт ОНӨҮГ	4,900	100	4,916	84
6	Түмэнцогт ОНӨҮГ		500		500
	Дүн	16,610	13,232	16,704	13,216
	Нийт дүн		29,842		29,920

1.2.4.3 Мал сүрэгт ангилалт хийсэн байдлыг авч үзвэл: Ангилалтад хамрагдсан малын 17.4 хувь буюу 6,371 толгой малыг цөм сүрэгт, 62.8 хувь буюу 18,801 толгой малыг үржүүлгийн сүрэгт, 15.9 хувь буюу 4,748 толгой малыг хэрэгцээний сүрэгт ашиглахаар ангилснаас гадна шинээр 7,850 толгой малыг ээмэглүүлсэн байна. Мал сүрэгт ангилалт хийсэн дээрх аж ахуйн нэгжүүд нь тус бүр гэрээний хэрэгжилтийг тайлагнаагүй зөвхөн маягтын дагуу ангилалтад хамрагдсан малын тоон мэдээг гаргаж хүргүүлжээ.

1.2.4.4 Харин МҮА-аас ангилалт хийсэн тоон мэдээг нэгтгэн дүгнэж тайлагнасан боловч малчдад мал сүргийн ангилалтын ач холбогдлын талаар хэрхэн зөвлөгөө, зөвлөмж хүргүүлсэн нь тодорхойгүй, өмнөх онуудад хийсэн ангилалтын тоон мэдээтэй харьцуулсан дүгнэлт хийж тайлагнаагүй байна. Энэ нь малын генетикийн нөөцийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1³ дэх хэсэгтэй нийцэхгүй байна.

1.2.4.5 Иймд мал сүрэгт үзлэг ангилалт хийж буй аж ахуйн нэгж бүрийн ажлын үр дүнг хэлэлцэн, судалгаа, шинжилгээний ажилд үнэлэлт дүгнэлт өгч, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, төлөвлөх нь зүйтэй байна.

1.2.5 МҮА-аас малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлсон судалгаанд дүн шинжилгээ хийгээгүй байна.

1.2.5.1 Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх, хяналт тавих ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар байгуулжээ.

1.2.5.2 Харин малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох ажлыг Үзэмчин хонь ХХК, Баясгалант сүрэг ХХК, Түмэнцогт ОНӨҮГ-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн байна.

³ Малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх, малд үзлэг, ангилалт хийх, удам гарваль, ашиг шимийн гарц, чанарыг тодорхойлох, үр төлийн шинж чанарыг үнэлэх, удам зүйн үнэлгээ хийх, үржил селекцийн ажлын үр дүнг хянан баталгаажуулах, үржүүлгийн хөтөлбөр боловсруулах, сайжруулагч малыг үржилд тохируулан сонгох, цөм сүрэг бүрдүүлэх, малд зохиомол хээлтүүлэг хийх, гойд ашиг шимт мал шалгаруулах, үржлийн малын үзэсгэлэн худалдааг зохион байгуулах, малын арчилгаа, маллагаа, тэжээллэгийн технологийн чиглэлээр малчин, мал бүхий этгээд, хуулийн этгээдэд мэргэжил, арга зүйн зааварчилгаа, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээнд хамааруулна.

1.2.5.3 Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох үйл ажиллагаанд 1,071 хээлтүүлэгч, 36,099 хээлтэгч мал хамруулсан бөгөөд судалгаанаас гарсан үр дүнг хүснэгтээр харуулав: Хүснэгт 5

Малын төрөл	хамрагдсан малын тоо	Судалгаанаас гарсан үр дүн		
		цөм сүрэг	үржлийн сүрэг	хэрэгцээний сүрэг
Буур	61	26	34	1
Ингэ	339	95	235	9
Азарга	650	345	276	29
Гүү	2,620	964	1,494	162
Бух	360	144	178	38
Үнээ	2,160	579	1,439	142
Эм хонь	18,910	4,787	12,047	2,067
Эм ямаа	12,070	3,358	7,502	1,210
ДҮН	37,170	10,298	23,205	3,658

1.2.5.4 Генетик нөөцийн төлөвийг цөм сүрэгт, үржлийн болон хэрэгцээний сүрэгт гэсэн байдлаар ангилж судалгааг дүгнэсэн байна. Судалгаанд хамрагдсан малаас 27.7 хувь 10,298 толгой малын цөм сүрэгт, 62.4 хувийг үржлийн сүрэгт, 9.9 хувийг хэрэгцээний сүрэгт ангилсан байна. Хэрэгцээний сүрэгт ангилагдсан 3,658

толгой мал нь нас хөгшрөлт, уналгаа эдэлгээ болон бусад шалтгаанаар ашиглагдах боломжгүй малыг оруулжээ.

1.2.5.5 Мал үржлийн албанаас генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох ажлын тайланд үндэслэн Малын генетик нөөцийн тухай хуулийн 8.1⁴-т заасны дагуу дэлгэрэнгүй судалгаа, дүн шинжилгээ хийгээгүй байна. Цаашид дээрх судалгаанд үндэслэн аймгийн хэмжээнд тааварлаг, ашиг шим сайтай мал сүргийг бий болгоход дүн шинжилгээ хийх, мэргэжлийн эрдэмтдээс зөвлөгөө авах, малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох ажлыг хариуцлагагүй гүйцэтгэсэн байгууллагуудад хариуцлага тооцох, дахин сайжруулж гүйцэтгэх ажлуудыг зохион байгуулах шаардлагатай байна.

1.2.5.6 Бог малын хээлтүүлэгчийн мал үржүүлэг, технологийн нэгжид төвлөрүүлэх ажлыг аймгийн Засаг дарга сумдын Засаг дарга нартай, ХХААГ-ын дарга сумдын МЭҮТ-ийн даргатай байгуулсан гэрээнд тус тус тусган ажиллаж байна.

1.2.5.7 Аймгийн хэмжээгээр таван төрлийн хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироог гарган дутагдах хээлтүүлэгчийг тооцон сумдад хүргүүлсний зэрэгцээ төрийн болон орон нутагт ажиллаж байгаа үржлийн аж ахуй, хээлтүүлэгч бойжуулах эрх авсан айл өрхөөс үржилд зориулан шинээр 1142 хээлтүүлэгчийг нөхөн тавиад байна.

⁴ Малын генетик нөөцийг дараахь зориулалтаар ашиглаж, судлан хөгжүүлнэ:

1.3 Үлийн цагаан оготной тэмцэх ажлын санхүүжилт 58.4 сая төгрөгийг зориулалт бус зарцуулж, гүйцэтгэлийг 82.7 хувийн хэрэгжилттэйгээр тайлагнажээ.

1.3.1 Аймгийн хэмжээнд 152.0 мянган га талбайд үлийн цагаан оготнын устгал хийж хэрэгжилтийг 82.7 хувьтай үнэлжээ.

1.3.1.1 Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй мэрэгч амьтан буюу үлийн цагаан оготной байгаль орчинд халгүй, энгийн механик аргаар болон микро биологийн аргаар 152.0 мянган га талбайд устгал хийсэн байна.

1.3.1.2 Энгийн механик аргаар үлийн цагаан оготной тэмцэхдээ тухайн сумын төрийн албан хаагч, малчин өрхтэй хамтран үлийн нүхийг ухах, утах, ус цутгах зэрэг аргыг ашиглан устгал хийсэн байна. Мөн төрийн байгууллагын албан хаагчдын хүчээр мэрэгч амьтнаар хооллолдог шувууны үүр, суултуур зэргийг байршуулсан байна. Харин үлийн цагаан оготнын тархалт ихтэй газруудаар хор цацах буюу микро биологийн аргаар устгал хийжээ.

1.3.1.3 Үлийн цагаан оготной тэмцэх ажлын хүрээнд сургалт сурталчилгааг давхардсан тоогоор 350 гаруй төрийн албан хаагч, иргэдэд явуулж, аймгийн онцгой комиссын гишүүдээр ахлуулсан ажлын хэсэг сумдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, ажлын гүйцэтгэл хяналт тавих зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

1.3.1.4 Аймгийн хэмжээнд мэрэгч амьтантай тэмцсэн ажил, сургалт сурталчилгаа, хэрэгжүүлсэн ажлын явцад хийсэн хяналт шалгалт болон үр дүнд аймгийн Мэргэжлийн хяналтын газраас хяналт шалгалт хийж, ажлын гүйцэтгэлийг 82.7 хувьтай үнэлжээ.

МХГ-аас хортон мэрэгчтэй тэмцсэн ажлын гүйцэтгэлийн 82.7 хувьтай үнэлсэн боловч ХХААГ-ын бэлчээр тэжээл, усан хангамж хариуцсан мэргэжилтэн энгийн механик болон микро биологийн аргаар тэмцсэн ажлын гүйцэтгэлийг харьцуулж аль арга нь илүү үр дүнтэй хэрэгжиж байгааг судалж тайлагнах, дүн шинжилгээ хийх шаардлагатай байна.

1.3.2 Зарим сумд үлийн цагаан оготно устгахад гүйцэтгээгүй ажлыг гүйцэтгэснээр мэдээлж, 58.4 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулснаар тайлагнажээ.

1.3.2.1 Үлийн цагаан оготно устгах ажлын хүрээнд ХХААХҮЯ-аас энгийн механик аргаар тэмцэхэд 260.0 сая, микро биологийн аргаар тэмцэх ажилд 48.0 сая, аймгийн Засаг даргын нөөц сангаас 12.2 сая нийт 320.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Үүнээс сумдад нийт дүнгээр 152.0 мянган га талбайд устгал хийгдэхээр 7.2-31.2 сая төгрөг хүртэлх төсөв буюу 281.7 сая төгрөгийг хуваарилжээ.

1.3.2.2 Хүснэгтээс харахад нийт санхүүжилтийн 87.9 хувь буюу 281.7 сая төгрөгийг сумдын ЗДТГ-т ажлын гүйцэтгэлд тулгуурлан олгосон байна. Харин ХХААГ оготно устгалын сургалт, сурталчилгаа, хордуулсан үрийн будааг тээвэрлэх хөлс, хяналт, шалгалтын томилолт, шатахуун зэрэгт 38.5 сая төгрөгийг зарцуулсан байна. Асгат, Дарьганга, Мөнххаан, Наран, Сүхбаатар, Эрдэнэцагаан сум оготно устгалын ажлын гүйцэтгэлийг буруу тайлагнаж, санхүүжилт авсан, мөн санхүүжилт оройтож орсон зэргээс шалтгаалан санхүүжилтийн зарцуулагдаагүй

үлдэгдлийг харилцагч байгууллагын дансанд шилжүүлж Төсвийн тухай хуулийн 6.4.1⁵, 6.4.8⁶, 16.5.5⁷, 41.2.2⁸, 41.2.3⁹, 43.5¹⁰, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5¹¹ дах заалтыг зөрчиж 58.4 сая төгрөгийн бодит бус авлага үүсгэж тайлагнасныг Санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоожээ.

БҮЛЭГ 2. Аймгийн хэмжээнд газар тариалан хөгжүүлэх нэгдсэн бодлого хэрэгжүүлээгүй, ХАА-н салбар мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай, худалдаа, үйлдвэр үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхээр ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байгаа боловч үр дүнг тооцох талаар хангалтгүй ажиллаж байна.

2.1 ЖДҮХС-ийн зээлийг хууль журмын дагуу олгож, төслийг зориулалтын дагуу хэрэгжүүлж байна.

2.1.1. ЖДҮХС-ийн зээлд хамрагдахаар ирүүлсэн төслийн 48.0 хувь хууль, журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангаагүйгээс буцаагджээ.

2.1.1.1 Тайлант онд ЖДҮ-ийг дэмжих хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар иргэн, аж ахуйн нэгжээс 8 үйл ажиллагааны чиглэлээр 3,890.1 сая төгрөгийн зээл хүссэн 52 төсөл ирүүлсэн байна. Иргэн аж ахуйн нэгжээс ирүүлсэн төслийг үйл ажиллагааны чиглэл, зээл хүссэн хэмжээг авч үзвэл:

- Фермер, эрчимжсэн аж ахуй, сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр 15 төсөлд 1354.4 сая төгрөг;
- Барилгын материал үйлдвэрлэлийн чиглэлээр 4 төсөлд 101.8 сая төгрөг;
- Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр 9 төсөлд 809.0 сая төгрөг;
- Газар тариалангийн чиглэлээр 4 төсөлд 336.1 сая төгрөг;
- Оёдлын чиглэлээр 4 төсөлд 269.4 сая төгрөг;
- Модон эдлэлийн чиглэлээр 3 төсөлд 107.0 сая төгрөг;
- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр 4 төсөлд 284.0 сая төгрөг;
- Бусад (засвар үйлчилгээ, контент, зочид буудал гэх мэт) чиглэлээр 9 төсөлд 628.4 сая төгрөгийн зээлд хамрагдахаар төсөл ирүүлсэн байна.

2.1.1.2 Зээлд хамрагдахаар ирүүлсэн төслийн иж бүрдлийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/119 дүгээр тушаалаар баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам”-ын 5.8¹², 5.9¹³ дэх хэсэгт заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллагыг 14, иргэнийг 12 шалгуур үзүүлэлтээр хүлээн авч бүртгэсэн байна.

2.1.1.3 Ирүүлсэн төслийг урьдчилсан байдлаар үнэлж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/119 дүгээр тушаалаар баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам”-ын 11.1.1¹⁴-т заасны дагуу баримт

⁵ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

⁶ төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

⁷ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

⁸ батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;

⁹ төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;

¹⁰ Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй.

¹¹ дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;

¹² ЖДҮЭ иргэн нь дараах материалудыг хавсаргасан байна.

¹³ ЖДҮЭ аж ахуйн нэгж нь дараах материалудыг хавсаргасан байна

¹⁴ Төслийн иж бүрдлийг шалгах ба иж бүрдлийг бүхэн хангасан төслийг дараагийн шатанд шилжүүлэх.

материалын иж бүрдэл дутуу 25 иргэн, хуулийн этгээдийн төслийг буцааж 27 төслийг дараагийн шатанд аймгийн төсөл сонгон шалгаруулах дэд хороогоор хэлэлцүүлжээ.

2.1.1.4 Шаардлагад нийцсэн төслийг дэд хороогоор хэлэлцэж 9 төслийг шалгаруулж 1,000.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэлийг авч үзвэл.

- Хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр 2 төсөлд 260.0 сая төгрөг
- Хөнгөн үйлдвэрийн чиглэлээр 3 төсөлд 144.8 сая төгрөг
- Эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр 3 төсөлд 542.9 сая төгрөг
- Үйлчилгээний чиглэлээр 1 төсөлд 52.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

2.1.2. Зээлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж төслийг зориулалтын дагуу хэрэгжүүлж байна.

2.1.2.1 ЖДҮ-ийг дэмжих хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн 7 төсөл үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагааг өргөтгөх, 2 төсөл шинээр үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эхлүүлж, 40 ажлын байр нэмэгдүүлэхээр төсөлд тусгагдсан байна.

2.1.2.2 Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэн, аж ахуй нэгжээс 3 төслийн үйл ажиллагаа төсөлд тусгагдсны дагуу хэвийн явагдаж байна. Тухайлбал:

- Баруун-Урт сумын иргэн М.Оюунгэрэл бялуу, нарийн боовны үйлдвэрлэлийн чиглэлээр зээлд хамрагдаж төсөлд тусгагдсны дагуу үйлдвэрлэлийн байрыг шинээр барьж, шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авч үйлдвэрлэлийг эхлүүлсэн.
- Мөнххаан сумын иргэн М.Төмөртоогоо арьсан гутлын үйлдвэрлэлийн чиглэлээр зээлд хамрагдаж, төсөлд тусгагдсны дагуу ажлын байрны өргөтгөл хийгдэж шаардлагатай тоног төхөөрөмж, материалыг худалдан үйлдвэрлэлийг хэвийн явуулж байна.
- Баруун-Урт сумын иргэн Ж.Мөнхгэрэл тавилга, буйдан засвар, оёдлын чиглэлээр зээлд хамрагдаж, төсөлд тусгагдсан тоног төхөөрөмж, материал зэргийг авч үйлдвэрлэсэн хувцасыг Зүүн бүсийн худалдааны төвд худалдан борлуулж байна.

2.1.2.3 Харин бусад зээлдэгчид төслийн санхүүжилтийг хүйтэн сэрүүний улирал эхэлсэн үед олгосонтой холбоотойгоор тайлант онд төслийг хэрэгжүүлээгүй бөгөөд одоогоор барилгын өргөлтөл, угсралтын ажлыг төсөлд тусгасны дагуу гүйцэтгэж байна.

2.2 Аймгийн хэмжээнд газар тариаланг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлээгүй, ХХААЯ-аас хийсэн үнэлгээгээр газар тариалангийн үзүүлэлтээр улсын хэмжээнд хамгийн доогуур үнэлэгджээ.


2.2.1 Аймгийн хэмжээнд газар тариалангийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх хэрэгцээ шаардлага үүссэн байна.

2.2.1.1 Засгийн газрын 2017 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийн 4.3¹⁵, Засгийн газрын 2017 оны 223 дугаар

¹⁵ Аймаг, нийслэлд “Хүнсний ногоо” дэд хөтөлбөр боловсруулан батлуулж хэрэгжүүлэх бөгөөд хөтөлбөр хэрэгжүүлэх салбар зөвлөлийг тухайн шатны Засаг дарга ахлан аймаг, нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга нар салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар ажиллана.

тогтоолоор батлагдсан “Жимс жимсгэнэ” үндэсний хөтөлбөрийн 7.3¹⁶-д заасны дагуу орон нутагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулаагүй байна.

2.2.1.2 Аймгийн хэмжээнд 2019 онд 66.2 га талбайд төмс, 32.7 га талбайд хүнсний ногоо тариалж, 516.1 тонн төмс, 207.6 тонн хүнсний ногоо хураан, авсан байна. Төмс, хүнсний ногооны тариалалт, ургац хураалтыг өмнөх онтой харьцуулж үзвэл.



(Эх сурвалж: 1212.mn цахим сайт, ХХААГ-ын 2019 оны тоон мэдээ)

2.2.1.3 Графикаас харахад тайлант онд тариалсан талбайн га тутмаас 7.8 центр төмс, 6.3 центр хүнсний ногоо хураасан байна. Харин өмнөх оны ургац хураалтын байдалтай харьцуулж үзэхэд төмс, хүний ногоо тариалах талбай нэмэгдсэн хэдий ч ургац хураалт буурсан байна. Тухайлбал: өмнөх онд төмс 57.2 га, хүнсний ногоо 29.5 га талбайд тариалж га тутмаас төмс 9.2 центр, хүнсний ногоо 8.3 центр хураасан нь тайлант оноос 1.4-2.0 центрээр илүү байна.

2.2.1.4 Харин чацаргана 29.1 га, шинээр үхрийн нүд 0.1 га талбайд тариалж чацаргана 4894.0 кг, үхрийн нүд 200 кг хураан, авсан бөгөөд чацарганын ургалт өмнөх оноос 19.9 хувиар бага байна.

2.2.1.5 Жимс жимсгэнийн тариалалтыг дэмжихээр Сүхбаатар, Мөнххаан сумдад чацаргана, үхрийн нүд шинээр тариалж, Тариалан эрхлэлтийг дэмжих сантай гэрээ байгуулж, “Жавхлант хан шарга” хоршоонд чацарганын суулгац нийлүүлсэн хэдий ч тариалах хугацаа болоогүй /бага/ суулгац нийлүүлснээс тариалалт хийгдээгүй учир тус суулгац цаашид ашиглах боломжгүй болсон байна.

2.2.1.6 Газар тариалангийн салбарт техникийн шинэчлэл хийх, хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор иж бүрдэл бүхий трактор 2, 32-120 мкв нийлэг хальсан 12 ширхэг хүлэмжийн техник, тоног төхөөрөмжийг Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас үнэ төлбөргүйгээр нийлүүлсэн. Дээрх хөрөнгөнөөс Сүхбаатар сумын “Жавхлант хан шарга” хоршоонд иж бүрдэл бүхий трактор, 3 ширхэг хүлэмж, Баруун-Урт сумын 3-р цэцэрлэг, Онгон сумын хилийн дугаар анги, Мөнххаан сумын ЗДТГ-т тус бүр 1, Баруун-Урт сумын эмэгтэйчүүдийн бүлэгт 5 хүлэмжийг ашиглуулахаар олгожээ.

¹⁶ Аймаг, нийслэлд хөтөлбөр хэрэгжүүлэх салбар зөвлөл ажиллаж, дэд хөтөлбөр боловсруулан батлуулж хэрэгжүүлэх бөгөөд түүнийг тухайн шатны Засаг дарга ахалж, гишүүдэд орон нутгийн төрийн захиргааны болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөл орж ажиллана.


2.2.1.7 ХХААГ-ын газар тариалан хариуцсан мэргэжилтэн ургац хураалтын байдлыг өмнөх онуудтай харьцуулан судалж, дүн шинжилгээ хийх, ургацын өсөлт бууралтын шалтгаан, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох зэрэг ажлуудыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна. Энэ нь тайлант оны төмс, хүнсний ногоо болон жимс, жимсгэнийн ургац өмнөх оноос буурсан шалтгаан, хүчин зүйлсийг тодорхойлж үнэлэлт дүгнэлт гаргаагүйгээс харагдаж байна.

2.2.1.8 Төмс, хүнсний ногоо, хүлэмжийн тариалалт, ургацын гарцыг нэмэгдүүлэх зорилгоор Ургамал хамгааллын тухай хуулийн 8.1.10¹⁷-т заасны дагуу Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгээр сумдын тариалангийн болон төмс, хүнсний ногооны зориулалтаар ашиглагдаж буй газарт хөрсний шинжилгээ, хүлэмжийн болон ил талбайн ургамлын өвчин хортны судалгааг тус тус хийлгэж, дүгнэлт гаргуулжээ.

2.2.1.9 Газар тариалан эрхлэх иргэдэд сургалт сурталчилгаа, арга зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх мэргэжлийн боловсон хүчин Сумдын ЗДТГ-т /агрономич/ дутагдалтай байна. Мэргэжлийн боловсон хүчин дутмагаас төмс, хүнсний ногооны тариалалтын хугацаа хоцрох, тариалалтын технологи алдагдах, ургац өмнөх оноос буурахад тодорхой хэмжээгээр нөлөөлдөг байна.

2.2.2 Аймгийн хэмжээнд 2,250 га-д улаан буудай тариалснаас 1,550 га буюу 68 хувьд ургац авч чадаагүй байна.

2.2.2.1 Аймгийн хэмжээнд 2019 онд улаан буудай 2,250 га, овьёос 600 га, арвай 100 га, малын тэжээл 700 га нийт 3,650 га талбайд тариалалт хийж, үр тариа 633.9 тонн, тэжээлийн ургамал 2,660.0 тонныг хураан авчээ.



2.2.2.2 Тайлант онд тариалсан талбайн га тутмаас 2.15 центр үр тариа хураан авсан бөгөөд га тутмаас авбал зохих хэмжээнээс 5-6 дахин бага үр тариа хураан авсан байна. Энэ нь Түмэнцогт сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Хэрлэн алтай ХХК-ний 1550 га талбайд тариалсан улаан буудай мөндөрт цохиулсантай холбоотой

байна. Тариалангийн талбай, ургац хураалтыг өмнөх онтой харьцуулж харуулав.

2.2.2.3 Үр тариаг өмнө оны тариалалтаас бага талбайд тариалсан ба энэ нь тариалан эрхэлж буй зарим аж ахуйн нэгжүүд тайланд онд өөрийн эзэмшлийн талбайд Тариалангийн тухай хуулийн 26.2¹⁸-д заасны дагуу тариалангийн газрын хөрсний төлөв байдал, чанарын үзүүлэлтийг тогтоох хөрсний агрохими, агрофизикийн шинжилгээнд хамруулж, уринш хийж гүйцэтгэсэнтэй холбоотой байна.

¹⁷ тариалангийн газрын ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлын байдалд 3 жил тутам судалгаа хийлгүүлж, дүгнэлт гаргуулах

¹⁸ Тариалангийн газрын хөрсний төлөв байдал, чанарын үзүүлэлтийг агрохими, агрофизикийн шинжилгээгээр тодорхойлно.

2.2.2.4 ХХААГ-аас газар тариалангийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид ТЭДС-аас хөнгөлөлттэй нөхцөлөөр шаардлагатай тоног төхөөрөмж болон зээл, тариалах үр авах зэрэгт туслах замаар дэмжлэг үзүүлж байгаа боловч тусгайлан төлөвлөгөө хөтөлбөр боловсруулж, батлуулаагүй, бодлогыг үр дүнтэй зохион байгуулаагүй байна.

2.2.3 Аймгийн хэмжээнд аж ахуйн нэгжүүд 5 төрлийн сортоор улаан буудай тариалж байна.

2.2.3.1 Улсын хэмжээнд улаан буудайн 20 сортыг нутагшуулсан бөгөөд үүнээс ихэвчлэн Дархан-165, Бурятская-34, Дархан-74, Дархан-131, Дархан-173, Халхгол-1, Орхон, Дархан-106, Алтайская-50, Сэлэнгэ, Дархан-47, Дархан-34, Дархан-166, Дархан-144 зэрэг сортуудыг тариалж байна.

2.2.3.2 ХАА-н мэргэжлийн эрдэмтдийн улаан буудайн сортуудад хийсэн сорилт шинжилгээ, судалгаагаар Дархан-72, Дархан-165, Бурятская-34, Дархан-74, Дархан-131, Дархан-173, Халхгол-1, Орхон, Бурятская-34, Дархан-106 зэрэг сортууд өвчинд тэсвэр, бусад хүчин зүйлд тэсвэртэй гэж дүгнэсэн байна.

2.2.3.3 Сүхбаатар аймгийн хэмжээнд Алтайский-325, Бурятская-79, Сэлэнгэ, Дархан-144, Алтайский-70 зэрэг сортын улаан буудайг тариалж байна. ХХААГ-ийн газар тариалан хариуцсан мэргэжилтэн /агрономич/ аймагт тариалагдаж байгаа сортуудад судалгаа, дүн шинжилгээ хийгээгүй байна.

2.2.3.4 Цаашид аймагт тариалагдаж байгаа улаан буудай болон бусад үр тарианы сортод мэргэжлийн дүн шинжилгээ хийж, орон нутгийн хөрсөнд нэн тохиромжтой үрийг тариалах талаар улаан буудайн тариалалт эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах шаардлагатай байна.

2.3 Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор үзэсгэлэн худалдаа, уралдаан тэмцээн зохион байгуулдаг боловч энэ нь үр дүнтэй арга хэмжээ төлөвлөсөн гэж харагдахгүй байна.

2.3.1 Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийн 34.9 хувийг хувиараа худалдаа, үйлчилгээ үзүүлж байгаа иргэд эзэлж байна.

2.3.1.1 Аймгийн хэмжээнд худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр 840 иргэн, аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж байгаагаас 293 /лангуу түрээслэн худалдаа эрхэлж байгаа иргэд ороогүй/ буюу 34.9 хувь нь хувиараа худалдаа үйлчилгээ эрхэлж байгаа иргэд байна.

2.3.1.2 Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, ХХААГ-ын 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд жижиг худалдаа, бизнес эрхэлж байгаа иргэн аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжих талаар тусгайлсан заалт тусгагдаагүй байна.

2.3.1.3 Харин ХХААГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан “Цагаан сар”, “Алтан намар”, “Эрүүл хүнс”, “Сүхбаатарт үйлдвэрлэв” зэрэг үзэсгэлэн худалгааг зохион байгуулж, идэвх санаачилгатай оролцсон жижиг бизнес эрхлэгчийг

урамшуулах, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчлах арга хэмжээг зохион байгуулсан байна.

2.3.1.4 Мөн орон нутагт жижиг өрхийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэдийг дэмжих, бүтээгдэхүүний борлуулах зорилгоор АЗДТГ-тай хамтран “Нэг суурин-Нэг бахархал” аяныг зохион байгуулсан байна. Мөн орон нутагт үйлдвэрлэгдэж байгаа брэнд бүтээгдэхүүний танилцуулгыг сум тус бүрээр нэгтгэн гаргах ажлыг зохион байгуулж Мөнхөд ундарч дэлгэрэх баялаг ХХК-тай гэрээ байгуулан, тухайн ажил хэрэгжиж байна.

2.3.1.5 ХХААГ нь АЗДТГ-ын бодлогын мэргэжилтэнтэй хамтран жижиг бизнес эрхлэгчийг дэмжих тусгай хөтөлбөр боловсруулах, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг аймгийн Засаг даргын 2020-2024 он хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусган, хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

2.3.2 Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хүрэлцээ, хангамжийн судалгааг журамд заасны дагуу гаргаж нэгтгэжээ.

2.3.2.1 Хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээ хангамжийн судалгааг Үндэсний статистикийн хорооны даргын 2015 оны А/12 дугаар тушаалаар батлагдсан “Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ын дагуу сум бүрээр тооцож нэгтгэсэн байна. Хүнсний хангамжийн судалгааг хүснэгтээр харуулав.

д/д	Бүтээгдэхүүний нэр	жишсэн нэг хүний хүнсний хоногийн хэрэгцээ, / гр/	жишсэн нэг хүний хүнсний жилийн хэрэгцээ, /кг/	жишсэн дундаж хүн амын жилийн хүнсний хэрэгцээ / тн/	Орон нутгаас нийлүүлсэн\тн\	Хангамжийн хувь
1	малын мах	120	43.8	2254.7	5161.4	100
2	загас	30	10.95	563.7	-	-
3	шувууны мах	40	14.6	751.6	-	-
4	сүү /үнээний 3.2 % тос/	160	58.4	3006.3	8	0.02
5	сүүн бүтээгдэхүүн	180	65.7	3382.1	2	-
6	гурил	100	36.5	1879	-	-
7	гурилан бүтээгдэхүүн	180	65.7	3382.1	621.9	18.3
8	төрөл бүрийн будаа	50	18.25	939.0	-	-
9	төмс	120	43.8	2254.7	474.2	21.0
10	хүнсний ногоо	260	94.9	4885.3	260.4	5.3
11	буурцагт ургамал	40	14.6	751.6	-	-
12	жимс, жимсгэнэ	200	73	3758	-	-
13	өндөг	20	7.3	375.8	-	-
14	ургамлын тос	23	8.395	432.4	-	-
15	цөцгийн тос 72% тослог	10	3.65	187.9	-	-
16	сахар, чихрийн зүйл	33	12.045	620.0	-	-

2.3.2.2 Судалгаанаас хүн амын хүнсний хэрэгцээний малын махыг 100 хувь, гурилан бүтээгдэхүүн 18.3 хувь, төмсний 21.0 хувь, хүнсний ногооны 5.3 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүний 0.2 хувийг дотоодоос хангадаг бөгөөд малын махнаас бусад бүтээгдэхүүнийг Улаанбаатар хот, хөрш зэргэлдээ аймгаас татан, хангаж байна.

2.3.2.3 Аймгийн хэмжээнд жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих бодлогыг үе шаттай хэрэгжүүлснээр сүү, сүүн бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногооны ихэнх хувийг дотоодоос хангах боломж харагдаж байна. Тухайлбал:

- Эрчимжсэн мал аж ахуйн, фермерийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэдийг бодлогоор дэмжих, төсөл хөтөлбөрт, сургалт, туршлага солилцох гэх үйл ажиллагааг эрчимжүүлснээр сүү, сүүн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх боломжтой юм.
- Газрын тухай хуулийн 29.2¹⁹-т заасны дагуу иргэдэд, төмс хүнсний ногоо тариалах зориулалтаар газрыг үнэ төлбөргүй эзэмшүүлэх, төмс хүнсний ногоо тариалах сургалтад хамруулах зэргээр хэрэгцээ хангамжийг нэмэгдүүлэх боломжтой юм.

2.3.2.4 Цаашид хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээ хангамжийг дотоодоос хангах хэмжээг нэмэгдүүлэх, мөн Засаг даргын 2020-2024 он хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тодорхой зорилт, арга хэмжээг тусган, төлөвлөх нь зүйтэй байна.

2.3.3 ЗГ-аас баталсан үндэсний хөтөлбөрийн хүрээнд оёдлын үйлдвэртэй болсон боловч одоогоор ажиллахгүй байна.

2.3.3.1 Засгийн газрын 2018 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн хүрээнд тус аймагт 5 үйлдвэр байгуулж 301 иргэнийг байнгын ажлын байраар хангахаар тусгасан.

д/д	Үйлдвэрийн нэр	Бүтээгдэхүүний нэр	Ажлын байр (хүн)
1	Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр	Мах, махан бүтээгдэхүүн	150
2	Цэвэр усны үйлдвэр	Цэвэр ус	6
3	Малын тэжээлийн үйлдвэр	Хорголжин тэжээл	15
4	Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэл	Баяжмалын уут, сурагчдын дүрэмт хувцас, ажлын хувцас	100
5	Ундааны ус хадгалах эко савны үйлдвэр	Ус хадгалах 40-60 литрийн эко сав	30

2.3.3.2 Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт үйлдвэржүүлэлтийг нэмэгдүүлэх зорилтыг тусгаж, Сүхбаатар хөгжил ҮТП-ыг түшиглэн “Сүхбаатар Про импекс” оёдлын үйлдвэрийг байгуулжээ. Тус үйлдвэр нь ажлын хувцас, уурхайн баяжмалын уут зэргийг оёж орон нутгийн аж ахуйн нэгжүүдэд нийлүүлж байсан боловч үйл ажиллагаа зогсонги байдалтай байна.

2.3.3.3 Мөн үндэсний хөтөлбөрийн хүрээнд цэвэр усны үйлдвэрийн өргөтгөл, мал мах бэлтгэх, дайвар бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх чиглэлээр төсөл ирүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийг дэмжин ЖДҮХС-ийн хөнгөлөлттэй зээлд хамруулж, Түмэнцогт суманд сүүлийн үеийн техник технологийн шаардлага хангасан мах махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр ашиглалтад орохоор баригдаж байна. Мөн Ай Си Ай ХХК цэвэр ус савлах үйлдвэрийг хөнгөлөлттэй зээлд хамрагдаж, хоногт савлах усны хэмжээг нэмэгдүүлсэн байна.

¹⁹ Энэ хуулийн 29.1-д зааснаас гадна гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тарих зориулалтаар иргэнд 0,1 га-гаас илүүгүй газар үнэ төлбөргүй эзэмшүүлж болно.

2.3.3.4 Харин малын тэжээлийн үйлдвэр, ундны ус хадгалах эко савны үйлдвэрийг байгуулах ажил хийгдээгүй байна. Тайлант онд малын тэжээлийн үйлдвэр байгуулах зорилготой иргэн, хуулийн этгээд ЖДҮХС-ийн зээлд хамрагдахаар төсөл ирүүлсэн боловч төсөлд тавигдах шалгуур үзүүлэлтийг хангаагүйгээс буцаагдсан байна.

2.3.4 Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний байгууллагуудын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх талаар зорилт дэвшүүлээгүй байна.

2.3.4.1 ХХААГ-ын тайлант оны үйл ажиллагааны хөтөлбөрт худалдаа, үйлдвэр, үйлчилгээний салбарын чиглэлээр 7 зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч чанар хүртээмжийг нэмэгдүүлэх талаар зорилт, арга хэмжээ төлөвлөөгүй байна.

2.3.4.2 Харин аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Хоол үйлдвэрлэл үйлчилгээнд эрүүл ахуйн зохистой дадал хэвшүүлэх замаар аймаг, бүс, улсын чанартай уралдаан тэмцээнд тогооч нарыг тогтмол хамруулж, нийтийн хоол, хүнсний үйлдвэрлэлийн салбарын үйлчилгээний чанарыг сайжруулах” зорилт арга хэмжээг төлөвлөсөн байна.

2.3.4.3 Засгийн газрын 2016 оны 287 дугаар тогтоолоор батлагдсан Сав баглаа боодол үндэсний хөтөлбөрийн хүрээнд ХХААХҮЯ, МХЕГ, ШӨХТГ-ын хамтарсан удирдамжийн дагуу "Алсыг харья-Органикийг сонгоё" сарын ажлын хүрээнд аймгийн МХГ-тай хамтран хүнсний худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжид хяналт, шалгалт, заавар зөвлөгөө өгсөн байна.

2.3.4.4 ХХААГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, ҮХҮТ-ын тайлан болон бусад холбогдох мэдээ тайланд зохион байгуулсан үзэсгэлэн худалдаа, аяны хэрэгжилт, уулзалт зөвлөгөөн зэргийн тайланг нэгтгэж боловсруулахдаа гарсан үр дүнг тоон мэдээ, тооцоо судалгаа, дүн шинжилгээнд тулгуурлан тайлагнахгүйгээр зөвхөн тоочсон хэлбэрээр тайлагнаж байгаа учир дутагдалтай байна.

2.3.4.5 Мөн үзэсгэлэн худалдаанд оролцсон шилдэг бүтээгдэхүүнийг иргэд олон нийтэд сурталчлах, арга технологийг таниулах ажлыг зохион байгуулж, нутгийн брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

2.3.4.6 Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа иргэн, аж ахуйн нэгжид холбогдох байгууллагатай хамтарсан хяналт шалгалтыг явуулж иргэдэд чанартай хүнсний бүтээгдэхүүнээр хангах талаар арга зүйн зөвлөгөө зөвлөмжийг боловсруулж ажиллах нь зүйтэй юм.

БҮЛЭГ 3. Үндсэн хөрөнгийн тооллогыг чанаргүй гүйцэтгэснээс хөрөнгө дутагдсан, хөрөнгийн хадгалалт хамгаалалтад эрсдэл учирсан, салбарын хэмжээнд хийгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр улсын дунджаас доогуур үнэлэгджээ.

3.1 Батлагдсан төсвийн 3.4 хувийг зориулалт бус зарцуулсан, хөрөнгийн тооллогоор 149.0 сая төгрөгийн хөрөнгө дутагдаж байна.

3.1.1 Батлагдсан төсвөөс 11.2 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан нь хяналт шалгалтаар илэрсэн байна.

3.1.1.1 Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөтөлбөр, зорилт арга хэмжээнд зориулан 343.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 330.7 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулжээ.

ХХААГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн тайлангийн аудит болон аймгийн СХДА-ын албанаас хяналт шалгалт хийгдэж дараах алдаа зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн аудитаар: Цалингийн урьдчилгаа олгож суутгаан тооцоогүй 0.6 сая, томилолтоор ажилласан албан тушаалтанд хоол унаа нэмэгдэл 0.3 сая төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1²⁰, 16 дугаар зүйлийн 16.5.5²¹, 41.2.2²², 41.2.3²³, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5²⁴ дахь заалтыг зөрчсөнд төлбөрийн акт тогтоосон байна. Харин Мал эмнэлгийн албаны даргыг ажлаас үндэслэлгүй халсан болохыг шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоосон бөгөөд ажилгүй байсан хугацааны цалин хөлс 8.8 сая төгрөгийг төсвөөс олгож, буруу шийдвэр гаргасан холбогдох этгээдээр буцаан төлүүлээгүй нь Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5²⁵, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1²⁶, 103.2²⁷ дахь заалтын дагуу төсөвт учирсан хохирлыг буруу шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтнаар эгүүлэн төлүүлэхээр заасны дагуу холбогдох байгууллагад албан шаардлага хүргүүлсэн байна.
- СХДА-ын албанаас хийсэн хяналт шалгалтаар: Зарим албан тушаалтанд 0.7 сая төгрөгийн томилолт давхардуулан олгосон бол 0.8 сая төгрөгийг жолоочийн тооцооны хуудсыг дутуу бөглөсөн, данс бүртгэлд 38.1 сая төгрөгийн авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулаагүй зэрэг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль бусад холбогдох журмыг зөрчсөнд албан шаардлага хүргүүлсэн байна.

3.1.1.2 Алтан цацал хоршоотой холбоотойгоор үүссэн өр төлбөрийн учир шалтгааныг тодруулж авч үзэхэд 2016 онд аймгийн засаг даргын шийдвэрээр ХХААГ-ын ҮХҮА-ны даргаар ахлуулсан (гшүүдэд Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨҮГ-ын дарга орсон) өр барагдуулах ажлын хэсэг томилогдон, ажилласан байна. Ажлын хэсэг Алтан цацал хоршооноос 22 тн буюу 22.0 сая төгрөгийн өртөг бүхий төмсийг (килограмм тутмыг 1000 төгрөгөөр бодож) хураан авч Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨҮГ-аар дамжуулан худалдан борлуулж, орсон орлогын зарим хэсгийг тус ОНӨҮГ-ийн үйл ажиллагаанд, зарим хэсгийг аймгийн орлогын

²⁰ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

²¹ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

²² батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах

²³ төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;

²⁴ дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах

²⁵ Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй.

²⁶ Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.

²⁷ Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна.

дансанд шилжүүлсэн нь баримтаар нотлогдож байгаа тул холбогдох албан тушаалтнуудтай тооцоо нийлж авлагын тодорхой хэсгийг барагдуулах шаардлагатай байна.

3.1.2 Орон нутгийн төсөв, Хөдөө аж ахуйн яамнаас олгосон нэмэлт санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулжээ.

3.1.2.1 Аймгийн засаг даргын захирамжаар 18.8 сая, ХХААЯ-аас 393.7 сая нийт 412.6 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрч 405.8 сая төгрөгийг зарцуулж 6.8 сая төгрөгийг дээд шатны төсөв захирагчийн дансанд төвлөрүүлсэн байна. Дээрх хөрөнгийн зарцуулсан байдлыг авч үзвэл:

- үлийн цагаан оготнотой байгаль орчинд халгүй аргаар тэмцэх ажлыг орон нутагт зохион байгуулах, хор тээвэрлэх зардалд 323.0 сая;
- малын генетик нөөцийн төлөв байдлын болон мал сүргийн ангилалтын үйл ажиллагаанд 44.4 сая;
- ариун цэврийн лабораторийн байрны засвар, тохижилт, сургалтын зардалд 6.0 сая;
- Аймгийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулсан уулзалт, зөвлөгөө, сургалт семинарын зардалд 22.5 сая;
- малын гоц халдварт шүлхий өвчлөлийн тархалтыг зогсоох зорилгоор хорио цээр тогтоох, ариутгах, халдваргүйжилд хийх болон бусад үйл ажиллагааны гарсан зардалд 9.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.1.3 Дансанд бүртгэлтэй 149.0 сая төгрөгийн 25 хөрөнгө тухай байгууллагад биетээр байхгүй байна.

3.1.3.1 Тайлант онд ХХААГ-аас МЭА-ыг салгаж бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийсэнтэй холбоотойгоор Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 513²⁸ дугаар тогтоолын дагуу 914.5 сая төгрөгийн өртөгтэй, авто тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг МЭГ-т дансны үнээр шилжүүлж, данс бүртгэлээс хассан байна.

3.1.3.2 Дансанд бүртгэлтэй хөрөнгийг түүвэрчлэн тоолоход 6 нэр төрлийн 149.0 сая төгрөгийн 25 ширхэг хөрөнгө биетээр тоологдоогүй байна.. Хүснэгтээр харуулав:

д/д	Дансны нэр	Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	Дансны үнэ /сая.төг/
1	Барилга байгууламж	Туулайн байр	1	0.4
2	Авто тээврийн хэрэгсэл	Трактор	1	15.3
3	Машин, тоног төхөөрөмж	Дунд оврын трактор	1	46.3
4		Хураагч	1	8.4
5		Хүлэмж 32мкв	6	6.7
6		Хүлэмж 120 мкв	4	12.9
7		Хүлэмж	1	4.6
8		мал нядалгааны тоног төхөөрөмж /ком/	10	54.4
НИЙТ ДҮН			25	149.0

²⁸ Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

3.1.3.3 Хөрөнгө дутагдсан шалтгааныг авч үзвэл: мал нядалгааны тоног, төхөөрөмж, туулайн байрнаас бусад хөрөнгийг зарим төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, иргэний бүлэг, хоршоонд ашиглуулж байжээ. Тухайлбал: Сүхбаатар сумын Жавхланта хан уул хоршоонд 64.3 сая төгрөгийн трактор, хүлэмж хураагч зэрэг машин тоног төхөөрөмж, Баруун-Урт сумын эмэгтэйчүүдийн бүлэгт 5.6 сая төгрөгийн хүлэмжийг түрээсийн гэрээ байгуулахгүйгээр ашиглуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14.2.1²⁹, 26.1³⁰, 27.1³¹ дэх заалтыг тус тус зөрчсөнд албан шаардлага хүргүүлээ.

3.1.3.4 Сүхбаатар ойжуулалт ойн анги ОНӨҮГ-т газар тариалангийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор 15.3 сая төгрөгийн тракторыг ашиглуулахаар өгсөн боловч тус ОНӨҮГ-т ашиглагдаагүй бөгөөд одоогоор тус трактор Түмэнцогт сумын нутагт /айлын гадаа эвдэрсэн/ байна. Мөн Хилийнр анги, Баруун-Урт сумын 3 дугаар цэцэрлэг, ХХҮГ-т газарт 9.4 сая төгрөгийн хүлэмжийг ашиглуулж байна. Харин ХХААГ-аас Бага-Өлгий ХХК-ий захирал Батболдтой Түмэнцогтын сумын нутагт байршилтай 112.4 сая төгрөгийн үнэтэй мал нядалгааны цэгийн барилга, 86.0 сая төгрөгийн үнэтэй дагалдах тоног төхөөрөмжийн хамт ашиглуулах гэрээг 2014 онд байгуулсан байна. Гэтэл тус компани барилга байгууламжийг зориулалтын дагуу ашиглаагүй учир гэрээг цуцалж, 2018 онд Сүхбаатарын зам нэгдэл хоршоонд ашиглуулах гэрээг байгуулсан байна. Одоогоор тус барилгын дагалдах тоног төхөөрөмж болох 54.4 сая төгрөгийн хөрөнгө алдагдсан байдалтай байгаа тул хууль хяналтын байгууллагад шилжүүлж, шалгуулахаар төлөвлөж байна.

3.1.3.5 Эндээс дүгнэж үзвэл хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтад тавих хяналт хангалтгүйгээс хөрөнгийн тооллогыг чанаргүй, нэр төдий хийж гүйцэтгэсэн, мөн төсвийн хөрөнгө үрэгдэж алга болсон, мөн дутагдсан зэрэг эрсдэлүүд үүсжээ.

3.1.4 Мал сүргийн үзлэг ангилалт, генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулалт хийлгүй шууд гэрээ байгуулж, гүйцэтгүүлжээ.

3.1.4.1 Тайлант онд тус газрын барилгад хэсэгчилсэн засвар хийлгэх 18.8 төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчийг ТБОНӨХБАҮХАТХ-ийн 33.2-т заасны харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж, Нижуна ХХК-тай гэрээ байгуулсан байна. Тендер сонгон шалгаруулалтыг хууль, журмын дагуу сонгон шалгаруулсан боловч гүйцэтгэгч ажлаа графикийн дагуу эхлүүлээгүй, урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлээгүй байхад гэрээний үнийн дүн болох 18.8 сая төгрөгийг шилжүүлж, авлагын дансанд бүртгэсэн нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 44.2³² дахь заалтыг зөрчсөн байна.

3.1.4.3 Мал сүргийн үзлэг ангилалт, генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох 49.5 сая төгрөгийн зөвлөх үйлчилгээнд сонгон шалгаруулалт зохион байгуулалгүй, Түмэнцогт ОНӨҮГ, Баясгалант сүрэг ХХК, Үзэмчин хонь ХХК-иар

²⁹ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах;

³⁰ Төрийн өмчит хуулийн этгээд нь өөрт олгогдсон эд хөрөнгийг энэ хуулиар тогтоосон журмын дагуу эзэмшиж ашиглана.

³¹ Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр концессийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно.

³² Захиалагч урьдчилгаа төлбөрийн дүнтэй тэнцүү хэмжээтэй гүйцэтгэгчийн ирүүлсэн энэ хуулийн 20.2-т заасан баталгааг үндэслэн урьдчилгаа төлбөр төлнө.

шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 36 дугаар зүйлийг зөрчсөнд албан шаардлага хүргүүлээ.

3.2 ХАА-н тасагт ажиллаж байгаа нийт ажилчдын 42.9 хувь нь мэргэжлийн бус бөгөөд мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байгаа нь үйл ажиллагаа доголдоход нөлөөлжээ.

3.2.1 Сумдын ХАА-н тасагтай байгуулсан гэрээний хэрэгжилт хангалтгүй байна.

3.2.1.1 Сумдын ХАА-н тасагтай гуравласан гэрээ байгуулж ажиллаж байгаа боловч ихэнх тасаг гэрээний биелэлтийг тайлагнаагүй, мэдээ судалгааг буруу гаргаж нэгтгэх, тухайн жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй байх зэрэг нийтлэг зөрчил гаргаж байна.

3.2.1.2 Засгийн газрын 2018 оны 267 дугаар тогтоолд заасны дагуу сумын ЗДТГ-ын бүтцийн “Мал эмнэлэг, үржлийн тасаг”-ийг “Хөдөө аж ахуйн тасаг” болгон өөрчилж 3 хүний орон тоо, чиг үүрэгтэйгээр ажиллаж байна. ХХААГ нь сумдын хөдөө аж ахуйн тасагтай гэрээ байгуулан, жилийн эцсээр дүгнэдэг байна.

3.2.1.3 Хамтран ажиллах гэрээ байгуулсан боловч 2019 онд Асгат, Баяндэлгэр, Дарьганга, Наран, Халзан сумдаас бусад ХАА-н тасаг жилийн эцсийн мэдээ тайлангаа ирүүлээгүй, нийт сумдын 61.5 хувь нь гэрээгээ дүгнүүлээгүй байна.

3.2.1.4 Гэрээний биелэлт, ажлын тайлангаа ирүүлсэн сумд нь шаардлага хангахгүй, загвар маягтын дагуу гаргаж хөтлөөгүй, хийсэн ажил нь тодорхойгүй зэрэг зөрчил дутагдал гарчээ. Энэ нь боловсон хүчин дутмаг, мэргэжлийн бус хүн ажилладагтай холбоотой юм. Мөн сумдын ХАА-н тасаг нь хамтран ажиллах гэрээний 3.2³³, 3.3³⁴ дахь заалт, хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтэн 2.5³⁵, 2.7³⁶ дахь заалт, ХХААГ нь 5.3³⁷ заалтыг тус тус хангалтгүй хэрэгжүүлж байна.

3.2.2 Сумын хөдөө аж ахуйн тасагт мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байна.

3.2.2.1 ХХААГ-ын даргын тушаалаар баталсан хүний нөөцийн стратеги төлөвлөгөө боловсруулсан байна. Тус стратеги төлөвлөгөөний 3.1-д заасны дагуу мэргэжлийн боловсон хүчнээр хангах үүднээс Дорнод аймгийн Политехникийн коллежтой хамтын ажиллагааны гэрээ байгуулж, дунд мэргэжлийн мал зүйч, малын эмч нарыг дээд мэргэжлийн мал зүйч бэлтгэх эчнээ сургалтад 12, ХААИС-ийн малын эмчийн магистрын эчнээ сургалтад 22 иргэнийг хамруулсан байна.

3.2.2.2 Харин сумдын ХАА-н тасагт мэргэжлийн боловсон хүчин хангалтгүй байна. Тухайлбал: аймгийн ТАСЗ-өөс гаргасан судалгаагаар сумдын ХАА-н тасагт Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан, Мал аж ахуйн

³³ ХХАА-н чиглэлээр хийгдэж байгаа ажил үйлчилгээний мэдээ тайланг хуулийн хугацаанд гаргаж, дээд шатны холбогдох байгууллагад тухай бүр тайлагнах

³⁴ ХХАА, Хөнгөн үйлдвэрийн чиглэлээр төр засаг болон аймаг орон нутгаас гаргасан шийдвэр, ХХААХҮ-ийн салбарын тэргүүлэх зорилтыг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж ХХААГ-т хүргүүлэх

³⁵ Салбарын чиглэлээр холбогдох байгууллагаас гаргасан арга хэмжээний төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

³⁶ ХХААГ-аас жилд 1-2 удаа ХАА-н тасгийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, дотоод аудит хийж үр дүнг тооцож зөвлөмж хүргүүлэх

³⁷ Гэрээний биелэлт хангалтгүй тохиолдолд ХХААГ-аас дээд шатны Засаг даргад уламжилж хариуцлага тооцуулна

үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан, ЖДҮ, худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтний 16 орон сул байна.

3.2.2.3 Мөн сумдын ХАА-н тасагт ажиллаж байгаа албан хаагчдын 42.9 хувь буюу 12 албан хаагч мэргэжлийн бус хүн ажиллаж байна. Сумдын ХАА-н салбарт мэргэжлийн бус хүн ажиллаж байгаа нь тухайн салбарын ойлголтгүйгээс иргэдэд заавар, зөвлөгөө, мэдээллийг буруу ташаа хүргэх, мэргэжлийн арга зүй дутагдсанаас салбарын ажил зогсонги байдалд хүрэх эрсдэл үүсэж байна.

3.2.2.4 Иймд сумдын ХАА-н тасгийн мэргэжлийн бус албан хаагчдыг хөрвүүлэн сургах, нэн шаардлагатай байгаа агрономич, мал зүйчдийг бодлогоор сурган мэргэшүүлэх арга хэмжээ авах шаардлага үүсжээ.

3.2.3 Байгууллагын сургалтын төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй байна.

3.2.3.1 ХХААГ-ын албан хаагчдаас сургалтын хэрэгцээ, шаардлагад тулгуурлан судалгаа дүн шинжилгээ хийж, сургалтын төлөвлөгөө боловсруулаагүй нь Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3³⁸ дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

3.2.3.2 Тайланд онд тус байгууллагын 11 албан хаагч мэргэжил, албан тушаалын дагуу давхардсан тоогоор гадаад, дотоодын 23 удаагийн сургалтад 1-20 хоногийн хугацаатай хамрагджээ. Сургалтад хамрагдсан албан хаагчид тухайн сургалтын талаар байгууллагын болон салбарын албан хаагч, тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн хуулийн этгээдэд танилцуулж байгаа эсэх нь тодорхойгүй байна. Зарим албан хаагчдын сургалтад хамрагдсан байдлыг авч үзвэл:

- БНХАУ-ын Бээжин, Хөх хотод зохион байгуулагдсан “2019 оны Монгол улсын ноос боловсруулах хөнгөн үйлдвэрийн мэргэжлийн сургалт” сэдэвт сургалтад 4 албан тушаалтан хамрагдсан байна.
- Мөн ХХАА-н салбарын удирдах ажилтны зөвлөгөөн, тариалан эрхлэгчдийн зөвлөгөөн, Хүнсний үйлдвэрийн ойн арга хэмжээнд 4 албан хаагч хамрагдсан байна.

3.2.3.3 Сургалтад хамрагдсан албан хаагчдын судалгааг хариуцсан мэргэжилтэн нэгтгэн гаргаж байгаа боловч тус сургалтын үр дүнг тооцох ажлыг орхигдуулсан байна. Иймд албан хаагчдаас зайлшгүй хамрагдвал зохих сургалтын судалгааг авч, ажлын байрны болон мэргэжлийн чиглэл сургалтын төлөвлөгөөг боловсруулж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй байна.

3.2.3.4 Харин сургалтад хамрагдсан албан хаагчид сургалтын ач холбогдол, үр дүнг байгууллагын албан хаагчид болон тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжид танилцуулж, мэдлэг мэдээллийг цаг алдалгүй хүргэж байх шаардлагатай байна.

³⁸ Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

3.2.4 ХХААЯ-аас хийгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр улсын дунджаас доогуур үнэлэгджээ.

3.2.4.1 Тус газар хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэдээ тайлан хариуцсан мэргэжилтэнтэй боловч тайлант онд дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө гаргаж, батлуулаагүй байна. Энэ нь Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журмын 6.1.1³⁹т заасныг зөрчиж байна. Мөн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн тайлант онд байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.

3.2.4.2 Харин тухайн байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтэд ХХААЯ болон аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, дүгнэсэн байна.

д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үнэлгээ /хувь/	
		улсын дундаж	тухайн байгууллага
1	Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ /50 оноо/	44.1	43.2
2	Бодлогын зорилтын хэрэгжилтийн үнэлгээ /20 оноо/	18.2	17.9
3	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ /20 оноо/	16.8	16.7
4	Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ /10 оноо/	8.8	8.6
НИЙТ ОНОО		87.9	86.4

3.2.4.3 ХХААЯ-ны хяналт-шинжилгээ, үнэлгээгээр салбарын дундаж үнэлгээнээс 1.5 оноогоор бага буюу 86.4 оноогоор үнэлэгдсэн бол аймгийн ХШҮХ-ийн үнэлгээгээр 87.6 оноогоор үнэлэгдсэн байна. ХХААЯ-ны үнэлгээг үзүүлэлт тус бүрээр нь улсын

дундажтай харьцуулж харуулав.

3.2.4.4 Хүснэгтээс харахад хяналт-шинжилгээ үнэлгээний үзүүлэлт бүрээр улсын дунджаас доогуур үнэлэгдсэн байна. Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээний үзүүлэлтийг нарийвчлан авч үзвэл Сүхбаатар аймгийн газар тариалангийн үзүүлэлт хамгийн багаар буюу 84.5 хувь, улсын дунджаас 4.8 хувиар бага үнэлэгдсэн байна. Үүнээс дүгнэж үзэхэд аймгийн хэмжээнд газар тариалангийн үйл ажиллагаа доголдож байгааг илтгэж байна.

3.2.4.5 Иймээс тус байгууллагын шат шатны албан тушаалтан дээд шатны байгууллагуудаас хийгдсэн хяналт-шинжилгээ үнэлгээнд дүн шинжилгээ хийж цаашид хэрэгжүүлэх ажлыг нарийн зохион байгуулалттай төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлага үүсжээ.

³⁹ захиргааны байгууллага жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөг батална. Энэхүү төлөвлөгөө нь тухайн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжийн төлөвлөгөө байж болно. Төлөвлөгөөнд зорилго, зорилт, хамрагдах байгууллага, нэгж, хэрэгжүүлэх хугацаа, зардал, хамтран оролцох байгууллага зэргийг тусгана.

Холбогдох байгууллагын санал:

СҮХБААТАР АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас, факс: 70518358

2020.12.07 № 1/269
танай _____-ны № _____-т

АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Санал хүргүүлэх тухай

Танай байгууллагаас ирүүлсэн нийцлийн аудитын тайлангийн төслийг байгууллагын ажилчдын хурал хийж ажил хариуцсан мэргэжилтнүүдэд танилцуулан доорхи саналыг хүргүүлж байна. Үүнд:

1.2.1.3. Мал тооллогоор явж байгаа комиссд мэргэжлийн хүн цөөн явдаг учир цэвэр эрлийз малын тоог гаргахдаа ач холбогдол бага өгч, буруу гаргадаг тохиолдол их байна.

1.2.5.3. Тухайн үүлдрийн үндсэн шаардлагыг хангасан үржлийн малыг ангилалтанд хамруулдаг бөгөөд үржилд тэнцэхгүй малыг бүртгэж хэрэгцээний сүрэгт хамруулдаг. Энэ нь нас хөгширсөн малыг ангилсан гэж харагдаж байна.

1.3.2.2. Санхүүжилт оройтож ирсэнтэй холбогдуулж үлийн цагаан оготнотой тэмцэх үлдэгдэл санхүүжилтийг төрийн сангийн гүйлгээ хаахтай зэрэгцүүлж шилжүүлсэнээс зарим сумдууд санхүүжилтаа татуулсан, холбогдох материалуудаа ирүүлээгүйн улмаас төлбөрийн акт үүссэн.

2.3.4. Тус газар нь Хүнсний үйлдэрлэл /нийтийн хоол/ түүний худалдааны чиглэлээр зорилт, арга хэмжээ хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөн ажилладаг бөгөөд хүнсний бус худалдааны асуудлыг хариуцдаггүй болно. Улсын хэмжээнд Худалдааны тухай хууль батлагдан гараагүйн улмаас эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Худалдааны байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, чанар хүртээмжийг сайжруулах талаар ямар нэгэн төсөв хөтөлбөрт хамрагдах, улсын төсвөөс хөрөнгө хуваарилдаггүй асуудал байсаар байна. Иймд энэ талаар аймгийн ЗДТГ-ын ХОХБТ-ийн хэлтэс /Худалдаа үйлдвэрлэл хариуцсан бодлогын мэргэжилтэн/-т тодорхой чиглэл өгөх

-ХХААХҮЯ-наас хөрөнгө оруулалтаар ирүүлсэн техник, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах талаар төрийн өмчийн хөрөнгийг ААН, иргэдэд түрээслэж болох талаар хариу авах

Санхүүгийн жилийн эцсийн тайлангаар "Алтан цацал" хоршоонд 36,1 сая төгрөгийн өглөг, авлагатай гарсан. Тус өглөг, авлагын талаар "Алтан цацал" хоршооны захирал Л.Халтартай уулзаж тодруулахад 22тн төмсийг 1,0 төгрөгөөр тооцож Нийтлэг

C:/My doc/balank A4

үйлчилгээний газарт хүлээлгэн өгснөөр өглөг бүрэн барагдсан гэх ба зөрүү 14,1 сая төгрөг барагдсан эсэх нь тодорхой бус байгаа юм. Нийтлэг үйлчилгээний газар нь төмсийг худалдан борлуулсан гэх боловч орлогыг одоо болтол төвлөрүүлээгүй байна.

Уг өглөгийг барагдуулахаар холбогдох байгууллагуудад удаа дараа хандсан ч тухайн үеийн албан тушаалтнууд, баримт материалууд байхгүй гэх шалтгаанаар шийдвэрлэгдэхгүй өдийг хүрсэн. Иймд дээрхи асуудлыг холбогдох хууль журмын дагуу шийдвэрлүүлэх саналтай байна.

ДАРГА  Т.ГАН-ОЧИР

Саналд өгсөн тайлбар:

Тайлангийн төслийг бүхэлд нь ерөнхийд нь зөвшөөрсөн бөгөөд ирүүлсэн тайлбарыг авч үзвэл:

- 1.2.1.3, 1.2.5.3, 1.3.2.2-т өгсөн тайлбар нь тайлангийн төсөлд тусгагдсан.
- 2.3.4-т чанар хүртээмжийг нэмэгдүүлэх хангалтгүй ажилласан талаар дүгнэсэн. Тайлангийн 2.3.4.1-т хүнс худалдаа үйлчилгээний чиглэлээр төлөвлөсөн зорилт арга хэмжээний талаар оруулсан.
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27.1-т эрх бүхий байгууллагын шийдвэрээр хөрөнгийг түрээсээр ашиглуулахаар заасан бөгөөд гарсан зөрчилтэй холбоотойгоор албан шаардлага хүргүүлж байгаа.
- 3.1.1.2-т тус авлагатай холбоотой асуудлыг тайлагнасан бөгөөд төмсний тооцоог Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨҮГ-тай тооцоо нийлж данс бүртгэлээс хасах талаар зөвлөмж хүргүүлсэн.

ДүГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Уст цэгийн тоог үе шаттайгаар нэмэгдүүлж байгаа боловч бэлчээрийн усан хангамж дутагдалтай, малын үүлдэр угсааг сайжруулах, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэхээр авч хэрэгжүүлж байгаа ажлууд хангалтгүй хэрэгжиж байна.
- Аймгийн хэмжээнд газар тариалан хөгжүүлэх нэгдсэн бодлого хэрэгжүүлээгүй, ХАА-н салбар мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай, худалдаа, үйлдвэр үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхээр ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байгаа боловч үр дүнг тооцох талаар хангалтгүй ажиллаж байна.

- Үндсэн хөрөнгийн тооллогыг чанаргүй гүйцэтгэснээс хөрөнгө дутагдсан, хөрөнгийн хадгалалт хамгаалалтад эрсдэл учирсан, салбарын хэмжээнд хийгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр улсын дунджаас доогуур үнэлэгджээ.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Аймгийн засаг даргад:

- ХАА-н салбарын боловсон хүчний хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх талаар бодлого боловсруулж, одоо ажиллаж байгаа мэргэжлийн бус албан хаагчдыг сурган ХАА-н чиглэлээр сурган дадлагажуулах ажлыг зохион байгуулах.
- Засгийн газраас баталсан “Хүнсний ногоо”, “Жимс жимсгэнэ” үндэсний хөтөлбөрийн хүрээнд орон нутагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийг боловсруулан, хэрэгжүүлж газар тариалангийн үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх ажлыг бодлогоор дэмжих

ХХААГ-ын даргад:

- Хөрөнгийн тооллогыг чанартай гүйцэтгэж, удирдлагын хяналтыг сайжруулах, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг дээшлүүлж, төрийн олон төрийн бус байгууллагад ашиглагдаж байгаа хөрөнгийг татан төвлөрүүлэх, ашиглуулж, эзэмшүүлэх тохиолдолд түрээсийн гэрээ байгуулж, орлогыг төсөвт төвлөрүүлэх.
- Байгууллагын сургалтын төлөвлөгөөг хууль, журамд заасны дагуу боловсруулан баталж, албан хаагчдыг ажлын байрны болон мэргэшлийг дээшлүүлэх сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах.
- Дээд шатны байгууллагаас хийгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд дүн шинжилгээ хийж, сахилга хариуцлага алдсан албан тушаалтанд хариуцлага тооцон ажиллах.

Нягтлан бодогчид:

- Алтан цацал хоршооноос хураан авсан төмсний борлуулалтын тооцоог аймгийн СТСХ, Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨҮГ-тай хийж авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах.
- Нөөцийн өвс, малын тэжээлийг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд толилуулж, тооллого тооцоог хууль, журамд заасны дагуу хийж гүйцэтгэн, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах.

Тасаг, нэгж, албан хаагчдад:

- ХХААГ-ын тасаг, алба нэгж албан хаагчид хэрэгжүүлсэн ажлын тайлан, төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэн зөв тоо, судалгаанд тулгуурлан харьцуулсан дүн шинжилгээ хийн тайлагнаж, цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргасан тооцоо судалгаатай уялдуулж боловсруулах.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэнд:

- Тайлант онд хэрэгжүүлэх хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын төлөвлөгөөг батлуулж хяналтаар гарсан зөрчлийг арилгуулах заавар зөвлөгөө, арга зүйг боловсруулж, зөрчил давтан гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналыг хүргүүлж байх.

ТАЙЛАНГ

ХЯНАЖ, БАТАЛГААЖУУЛСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
М.НАРАНТУЯА

ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР Г.ДАВАА

БИЧСЭН: АХЛАХ АУДИТОР С.АРИУНБАЯР

АУДИТОР Б.АРИУНЗУЛ